

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 10 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж, 3 асуудал хэлэлцэж, аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, 2018 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийн явц, түүнд оруулах өөрчлөлтийн тухай эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2019 оны төслийн тухай хэлэлцэж Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр уламжлав.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 36 өргөдөл бичгээр хүлээн авч, 21 өргөдлийг шийдвэрлэж, 15 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт 24 өргөдөл бичгээр хүлээн авч, 19 өргөдлийг шийдвэрлэж, 5 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 2 сувгаар 29 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 28, биечлэн 1 санал хүсэлт ирүүлснээс гомдол 22, санал хүсэлт 6, шүүмжлэл 1 бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 25 иргэний санал хүсэлтэд хариу өгч шийдвэрлэлт 86.2 хувьтай байна. Үүнд: цахилгааны асуудлаар 1, халаалтын асуудлаар 18, орчны эрүүл ахуйн асуудлаар 2 бусад асуудлаар 8 иргэн тус тус хандсан.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцгаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу тайлант сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 1 гомдол, 1 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, 2 санал хүсэлтийн хариуг илгээж шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Нэг цонхны үйлчилгээ аймгийн ЗДТГ-т байрлаж Улсын бүртгэлийн хэлтсийн Жаргалант сумын 2 бүртгэлийн байцаагч 11 төрлийн үйлчилгээгээр 856 иргэнд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 3 мэргэжилтэн 15 төрлийн үйлчилгээгээр 2882 иргэнд нийт 5 мэргэжилтэн 26 төрлийн үйлчилгээгээр 3738 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллав.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцооны ISO:9001 стандартыг нэвтрүүлэх арга хэмжээг “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай хамтран хэрэгжүүлж, сургалт, Gap analysis буюу зөрүүгийн шинжилгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А|175 дугаар тушаалаар тус стандартыг нэвтрүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах чиг үүрэг бүхий “Чанарын удирдлагын баг” томилон багийн ажиллах 16 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 10 дугаар сард улсын төсвөөс авах санхүүжилт бүрэн ирж, цалин хөлс, тогтмол зардал, ОНХС, ОНХО-ын зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.

Аймгийн ИТХ-ын 7 дугаар хуралдаанаар 2017 оны төсвийн гүйцэтгэл, 2018 оны төсвийн гүйцэтгэлийн явц, орон нутгийн төсвийн 2017 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлын дансны үлдэгдэл, 2018 оны хөрөнгө оруулалтын хэмнэлтийг зарцуулах, урсгал төсөвт зохицуулалт хийхээр 2018 оны төсөвт тодотгол хийж, өөрчлөлт оруулах саналыг хэлэлцүүлж батлуулав.

Дарви, Цэцэг, Үенч, Булган, Ховд сумын санхүүгийн алба, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналт хийж, газар дээр нь ажлыг сайжруулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

Төсвийн жил дуусах гэж байгаагаар холбогдуулан сумдын Засаг дарга нарт “Санхүү, төсвийн талаар авах арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 1/2316 дугаар албан бичиг хүргүүлж, 2017 оны төсвийг хэрэгжүүлэхэд гарсан зөрчлийг арилгах, орон нутгийн төсвийн батлагдсан төлөвлөгөөг биелүүлэх, санхүүгийн жилийн үлдэж буй хугацаанд санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулан өр, авлагагүй гарах талаар арга хэмжээ авч ажиллах чиглэл өгч ажиллав.

Засгийн газрын 2018 оны 263, 264 дүгээр тогтоол гарч төрийн албан хаагчдын цалинг 8-30 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын А/579 дүгээр захирамжаар орон нутгийн удирдлагын байгууллагуудын ажиллах хүчний зардлыг 98,1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын ажиллах хүчний зардлыг 902,7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталж, эх үүсвэрийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гүйлгэн зохицуулалт хийлээ.

Орон нутгийн төсвийн орлого 3 дугаар улирлын байдлаар төсвийн орлогод 6,548.2 сая төгрөг орж төлөвлөгөө 98,2 хувийн, үүнээс татварын орлогоор 5,844.5 сая төгрөг орж төлөвлөгөө 96.9 хувийн, татварын бус орлогоор 700.4 сая төгрөг оруулж төлөвлөгөө 118.9 хувийн биелэлттэй урьдчилсан дүнтэй байна.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагуудын өөрийн орлогод 191,9 сая төгрөг орж төлөвлөгөө 119,9 хувийн биелэлттэй байна.

Энэ улирлын байдлаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийн орлогод 300,4 сая төгрөг оруулахаас 591,0 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 290,6 сая төгрөгөөр буюу 96,7 хувиар давуулан биелүүлсэн.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 45,726.4 сая төгрөгт хүрч төсөвлөснөөс 4,656.0 сая төгрөгөөр, үүнээс орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зарлага 12,810.7 сая төгрөгт хүрч, 701.1 сая төгрөгөөр, орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын зарлага 27,139.9 сая төгрөгт хүрч 1,572.2 сая төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардал 1,800.2 сая төгрөгт хүрч 308,5 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зарлага

2,280,8 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 632,6 сая төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн зарлага 458,9 сая төгрөгт хүрч 911,6 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй гарсан урьдчилсан дүнтэй байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх салбарын төсвийн өр 171,9 сая, авлага 103,1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс өр 22,6 сая төгрөгөөр буурч, авлага 27,9 сая төгрөгөөр өссөн.

Эрүүл мэндийн салбарын төсвийн зарлага 3,082.9 сая төгрөг гарсан нь төлөвлөснөөс 214,2 сая төгрөгөөр дутуу гарч, өр 40,4 сая, авлага 2,7 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 47,8 сая төгрөгөөр өсөж, авлага 1,2 сая төгрөгөөр буурсан байна. Өрийг оны эхэнтэй харьцуулахад 24,1 сая төгрөгөөр өссөн байна.

Боловсрол, соёл, спортын салбарын төсвийн зарлага 23,561,9 сая төгрөг гарсан нь төлөвлөснөөс 1,338,7 сая төгрөгөөр дутуу гарч, өр 264,2 сая, авлага 67,4 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 48,0 сая төгрөгөөр буурч, авлага 26,9 сая төгрөгөөр өссөн байна. Өр оны эхэнтэй харьцуулахад 166,7 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт өрийг эдийн засгийн ангиллаар авч үзэхэд ажиллах хүчинтэй холбогдсон зардал 323,6 сая, тогтмол зардал 13,5 сая, эм, хоол 26,9 сая, шатахууны 39,3 сая, урсгал засвар 31,7 сая, бараа үйлчилгээний бусад зардал 62,5 сая төгрөгийн өр ихэнхийг эзэлж байна.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтанд 2,485,1 сая, орон нутгийн хөгжлийн санд 2,077,9 сая, байгаль хамгаалах санд 148,3 сая, замын санд 330,0 сая, хөшөөт хөгжлийн санд 750,0 сая, нийт 5791,3 сая төгрөг төлөвлөж, 3 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэлээр орон нутгийн хөрөнгө оруулалтанд 1,717,8 сая төгрөг зарцуулсан нь 69,2 хувьтай, орон нутгийн хөгжлийн санд 1,091,1 сая төгрөг зарцуулсан нь 52,5 хувьтай, байгаль хамгаалах санд 111,9 сая төгрөг зарцуулсан нь 75,4 хувьтай, замын санд 161,3 сая төгрөг зарцуулсан нь 48,9 хувьтай, хөшөөт хөгжлийн санд 567,5 сая төгрөг зарцуулсан нь 75,6 хувьтай, нийт 3,649,6 сая төгрөг зарцуулсан нь 63,0 хувьтай байна.

Сумдын 2018 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,065,1 сая, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд 2,372,7 сая төгрөг төлөвлөснөөс 3 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэлээр орон нутгийн хөрөнгө оруулалтанд 843,4 сая төгрөг санхүүжүүлсэн нь 79,2 хувьтай, орон нутгийн хөгжлийн санд 2,073,8 сая төгрөг санхүүжүүлсэн нь 87,4 хувьтай байна.

Улсын төсвийн эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн сайдын багцаас 1,540,5 сая, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын багцаас 356,9 сая, ЗГХЭГ-аас 394,3 сая, Сангийн сайдын багцаас 650,0 сая, нийт 2,941,7 сая төгрөгийн санхүүжилт ирснийг бүрэн олгосон нь төсөвлөснөөс 82,8 хувьтай байна. Тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн улсын бүртгэл, статистикийн хэлтэстэй тулгалт хийж Тахаст болон Tips програмд бүртгэл хийн ажиллалаа. Үүнд: ХХК 61, Нөхөрлөл 7, төсөвт байгууллага 2, ОНӨҮГазар 2, олон нийтийн байгууллага 1,ТББ-15, салбар 6 нийт 94 аж ахуйн нэгж байгууллага бүртгэсэн байна.

Хөндлөнгийн мэдээллүүдийг цуглуулах, бүхий л эх үүсвэрийг татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж хэвших, хөндлөнгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтийг хангаж ажилласнаар 662 ширхэг 4979.7 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээллүүд цуглуулав.

Татварын хяналт шалгалтанд 96 татвар төлөгч байгууллагыг хамруулаа. Шалгасан татвар төлөгч бүрт гаалийн болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийснээр шалгалтын явцад 8687.9 сая төгрөгийн зөрчилд 456.3 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 141.5 сая төгрөгийн торгууль, 110.8 сая төгрөгийн алданги, нийт 708.7 сая мянган төгрөгийн нөхөн татвар торгууль, алданги ногдуулав.

ӨНЭЗ-ийн судалгааг Жаргалант сумын Бичигт, Магсаржав, Дарви сумын Булган, Үенч сумын Хөхүзүүр, Булган сумын Алагтолгой Ховд сумын Цагаан бургас, багуудад, АХ-ний судалгааг Жаргалант сумын Наран, Дарви Сумын Мөрөн, Ховд сумын Баруун салаа багуудад нийт 88 өрхөд хийж дуусгав.

Аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтээр 10 сарын танилцуулга, аймгийн ерөнхий мэдээлэл багтаасан өврийн дэвтэр гаргаж, хэлтсийн вэб сайтад байршуулж, ЗДТГ-ын хэлтэс агентлагын дарга нарт хүргүүлэв.

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа хийх баг манай аймагт 10 дугаар сарын 8-ний өдрөөс 21 хоног ажиллаж, Жаргалант сумын Хайрхан, Тахилт, Зэрэг сумын Бураа, Булган сумын Баянсудал, Мөст сумын Давст, Буянт сумын Норжинхайрхан, Ховд сумын Баруун салаа багуудад нийт 200 өрхийг хамрууллаа. Судалгааны ажлын явцад ҮСХ-оос болон НҮБ-аас хяналтын баг ирж хяналт хийлээ. Хүн ам, орон сууц, 2020 оны тооллогын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө боловсруулж сум багуудад хүргүүлэв.

Ерөнхий боловсролын сургуулийн 1-11 дүгээр ангийн математикийн сургалтын цөм хөтөлбөрийн статистикийн хичээлийн агуулгыг сайжруулж, сурагчдын математик, статистикийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан "Статистикийн арга зүйн гарын авлага"-ыг Боловсролын хүрээлэн, Үндэсний статистикийн хороо хамтран боловсрууллаа. Тус гарын авлага нь сурагч тухайн суралцахуйн зорилтод хүрэхийн тулд ажиллах жишээ даалгавар, багш нь сурагчдыг хэрхэн чиглүүлэх заавар, сургалтад хэрэглэх сургалтын материал, бие дааж бодох бодлого, явцын үнэлгээ, нэмэлт бодлого бүтэц, агуулгатай юм.

Гурав: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Дэлхийн багш нарын 24, Монголын багш нарын 52 дахь өдрийг угтан багш, сурагч, эцэг эхийн дунд “Би багш бол” эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж уралдаанд багш 76, сурагч 41, эцэг эх 16 нийт 133 эсээ ирснээс дүгнэж шалгаруулан “Чадварлаг багш” орон нутгийн дэд хөтөлбөрөөс шагнаж урамшууллаа. Мөн 2017-2018 оны хичээлийн жилд амжилт гаргасан сургууль, багш нарыг шагнаж урамшууллаа. Тус хичээлийн жилд ажлын амжилтаараа Жаргалант

сумын Цаст-Алтай цогцолбор Прогресс, Буянт сумын сургууль, Зэрэг сумын цэцэрлэг, Жаргалант сумын 6, 14 дүгээр цэцэрлэгүүд үйл ажиллагаагаараа манлайллаа.

Жаргалант сумын 5 дугаар цэцэрлэгийн багш Н.Оюунцэцэг, Прогресс сургуулийн багш Болдцэцэг, Дарви сумын сургуулийн багш Ж.Баттөмөр, ахмад багш Д.Уранбилэг нарын “Эрдмийн өргөөний эзэд” хөрөг нэвтрүүлэг, БСШУС-ын яамнаас зохион байгуулсан “Багшийн хөгжил-2018” аяныг аймгийн сургууль, цэцэрлэгийн багш, эцэг эх, хүүхэд багачуудын дунд зохион байгуулж, сургуулийн удирдлагуудын дунд бүтээлч санааны уралдаан, эцэг эхчүүдийн дунд эсээ бичлэгийн уралдаан, сурагчдын дунд гар зураг, эсээ бичлэгийн уралдаан тус тус зохион байгууллаа.

“Олон нийтийн оролцоот сургууль-Хүний хөгжлийн төв” орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, эцэг эхийн төлөөлөл, сургууль, цэцэрлэгийн удирдлагууд, багш нарын төлөөлөл нийт 300 хүн оролцсон зөвлөгөөн зохион байгууллаа.

Тус зөвлөгөөний хүрээнд сургууль, цэцэрлэгүүд өөрсдийн ажлын туршлагаараа үзэсгэлэн гаргасан нь харилцан мэдээлэл солилцох, туршлагаа хуваалцах сайн ажил боллоо. Зөвлөгөөнөөс сургууль, цэцэрлэгийг олон нийтийн оролцоонд тулгуурлан хүний хөгжлийн төв болгон хөгжүүлэхэд 5 үндсэн чиглэл бүхий зөвлөмжийг хэлэлцэн гаргалаа.

Зөвлөх зэргийн шаардлага хангасан 6 багшийн материалыг БМДИ-д хүргэж, мэргэжлийн тэргүүлэх зэрэгт хүсэлт ирүүлсэн 146 багшийн материалыг мэргэжилтний зөвлөлөөр хэлэлцэн 106 багшид БСУГ-ын даргын тушаалаар “Тэргүүлэх” зэрэг, шаардлага хангасан кабинетад “Кабинетын гэрчилгээ” олгов.

“Чадварлаг багш” дэд хөтөлбөрийн хүрээнд “Хичээлийн судалгаа” аян өрнүүлж Жаргалант сумын 6 дугаар сургуульд түшиглэн бүх судлагдахуунаар зохион байгууллаа. Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэлийг сайжруулах зорилгоор зохион байгуулагдсан “Биологи-Их сорил”-ийг зохион байгуулж, “Дижитал сургалтын арга зүй” сургалтад хамрагдах багш нарын судалгаа гаргаж БСШУСЯ-д хүргүүлж бэлтгэл ажлыг хангаад байна.

Жайка олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Суурь боловсролын сургалтын чанарыг сайжруулахад мэдээлэл харилцааны технологийг ашиглах нь” төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй сургуулийн сургагч багш бэлтгэх сургуулийн 1 дүгээр бүсийн сургалтыг Зэрэг суманд зохион байгууллаа. БОАЖГ-аас сурагчдыг байгаль орчноо хайрлах хамгаалах сэдэлтэй болгох зорилгоор зохион байгуулж буй “Ногоон паспорт аянд Жаргалант сумын 7 сургуулийн эко клубын 140 сурагч нэгдээд байна.

Дэлхийн гар угаах тэмдэглэлт өдрийг тохиолдуулан Эрүүл мэндийн газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран “Цэвэр гар—Эрүүл амьдралын жор” сэдэвт ажлыг 2-3 дугаар ангийн 2090 сурагчдыг хамруулан зохион явууллаа.

АНУ-ын Гадаад харилцааны яамны боловсрол, соёлын асуудлыг эрхэлсэн товчооноос санхүүждэг “ФЛЕХ” хөтөлбөрийн 2 дахь удаагийн баруун бүсийн шалгаруулалтыг зохион байгууллаа.

Даяаршлын түрлэг дэх Монголын соёлын өвийн дархлааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг илтгэх, цаашдын гарц ба шийдлийг тодруулах зорилгоор зохион байгуулагдсан зөвлөгөөнийг БСШУСЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг СУГ хамтран зохион байгуулсан зөвлөгөөнд холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулж Соёлын биет бус өвийг судлах, сурталчлах, хадгалалт хамгаалалтыг сайжруулахад болон олон нийтийн оролцоог идэвхжүүлэхэд орон нутгийн үүрэг, оролцоо сэдвээр илтгэл мэдээлэл хийлээ.

Аймгийн ерөнхий боловсролын 25 сургууль, насан туршийн боловсрол төв, БСУГ, төрийн өмчийн 32 цэцэрлэг, хувийн өмчийн 13 цэцэрлэгийн мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн системд оруулах үйл явцыг хянаж, алдаатай оруулсан мэдээллийг засаж дуусгав.

Аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа гаргаж хобогдох байгууллагад хүргүүлээ. Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яамнаас боловсруулсан “Сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийн үнэлгээ” хийх удирдамжийн дагуу сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй баг Жаргалант сумын сургууль цэцэрлэг, сумдын нийгмийн бодлогын ажилтнаар ахлуулсан баг сумдын сургууль цэцэрлэгт тус үнэлгээ хийж үнэлгээний тайлан, төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний судалгаа гаргаж яаманд хүргүүлээ.

Соёл, Спортын чиглэлээр: Аймгийн Музейн байгууллагын нэгдсэн төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Музейн хадгалалт, хамгаалалтыг олон улсын стандартад ойртуулж, үзмэр худалдан авалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлнэ” заалтын хүрээнд үзүүлэлийн танхимын 9 ширхэг шилэн хоргоны суурь шинэчлэн үзмэрийн аюулгүй байдлыг ханган ажиллахын зэрэгцээ шашин болон археологийн танхимуудын шилэн хоргоны сууриудыг сольж, танхимын өнгө үзэмжийг сайжруулан ажиллахын зэрэгцээ устах аюулд ороод байгаа цоохор ирвэсийг хамгаалах үйлсэд нэгдэн Байгаль, газарзүйн танхимд ирвэсийн булан байгууллаа. Энэхүү булангаар дамжуулан гадаад, дотоодын жуулчид, ард иргэдэд ирвэсийг үзүүлэхийн зэрэгцээ музейн боловсролын ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиуд, Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, Их дээд сургууль, коллежийн оюутнуудад ирвэсийн талаарх ойлголтыг бодит орчинд нь сурталчлан таниулан ажиллах зорилготой.

Үзмэрийн танхим болон ажилчдын өрөө тасалгааны шатсан болон гэмтэлтэй гэрэл сольж, цахилгааны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Мөст сумын нутагт үл хөдлөх дурсгалын тооллогын ажил зохион байгуулж, 52 дурсгалт газрын 100 гаруй үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэл мэдээллийн санд баримтжуулав.

2018 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар баруун Монголын олон угсаатны өв соёлтой танилцахаар 70 том хүн, 60 хүүхэд, 27 гадаад үзэгч нийт 170 үзэгч Музей болон Өв соёлын хүрээлэнг үзэж сонирхсон.

Төрийн шагналт Ардын жүжигчин Ж.Чулууны нэрэмжит Алтан гадас одонт Хөгжимт драмын театр 2018 оны өвөл цагийн уран бүтээлийн 81 дэх жилийн үзвэрийн нээлтийн үйл ажиллагааг тохиолдуулан Ж.Чулууны 90 жилийн ойд зориулан үндэсний цөөхүүл болон ёочин хөгжмийн уралдаан, хүндэтгэл үзүүлэх 4 уран бүтээлийг сэргээн туурвих ажил зохион байгуулах ажлын комисс томилогдон ажиллаж байна. Аймгийн Засаг даргын захирамжын дагуу “Цэвэрч Ховд” сарын аяны хүрээнд 2 удаа нийтийн цэвэрлэгээнд ажиллаж, бүх нийтээр мод тарих өдрөөр 45 уран бүтээлч, ажилчид 60 хайлаас тарив.

Аймгийн Биеийн тамир спортын газрын 2018 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Спорт зааланд их засвар, спорт цогцолборын иж бүрэн камержуулалтын ажил хийгдэж байна.

2018 оны 10 дугаар сарын 18-19-ны өдрүүдэд Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан Спорт ба хөгжил сэдэвт биеийн тамир, спортын салбарын улсын зөвлөгөөнд байгууллагын удирдлага 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцож мэдээлэл солилцов.

Үндэсний бөхийн өсвөрийн УАШТ 2018 оны 10 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулагдаж тус тэмцээнээс М.Баяржавхлан Хүрэл медаль хүртсэн амжилттай оролцов.

Аймгийн Нийтийн номын сан тайлант сард 483 уншигчдад шинээр карт нээж 5596 ирцэд 7126 ном олгож үйлчиллээ.

Төрийн хошой шагналт, үгийн урлагийн нэрт төлөөлөгч, өгүүллэгийн дархчуулын нэг сонгодог зохиолч Ч.Лодойдамбын 101 насны ойд зориулан зохион байгуулсан “Зохиолчийн уран бүтээлээр ном бүтээх” уралдаанд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн Цаст-Алтай цогцолбор сургууль, дэд байранд ЕБС-ийн 6 дугаар сургууль, гутгаар байранд Прогресс сургууль, тусгай байранд 12 жилийн 3 дугаар сургууль, Цаст-Алтай цогцолбор сургуулийн бүтээлүүд шалгарлаа. “Монголын зохиолчдын уран бүтээлийг хэн сайн мэдэх вэ?” танин мэдэхүйн АХА тэмцээнд Тэргүүн байрыг Прогресс сургуулийн 8а ангийн сурагч Н.Уянгалянхуа, дэд байрыг ЦАЦ сургуулийн 8б ангийн сурагч Б.Чинболор, гутгаар байрыг 6 дугаар сургуулийн Н.Нарантуяа, 3 дугаар сургуулийн 8в ангийн О.Сугарнаран нар шалгарлаа. Мөн энэ өдөр зохиолчийн өгүүллэгүүдээр “Зохиолоос олж авсан ухаарал” нээлттэй хэлэлцүүлэг, ХХ зууны шилдэг зохиол болох Тунгалаг Тамир романаар уншигчдын бага хурлыг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд сэтгэл зүтгэл гаргаж оролцсон багш сурагчдаа талархан алдаршуулав.

Аймгийн ном бүтээл туурвидаг зохиолч уран бүтээлч хүүхэд, залуучууд, ахмад 3 үеийн уулзалт зохион байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эерэг хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн Орчны

эрүүл мэндийн тэмдэглэлт өдрийг “Даян дэлхийн хүнсний аюулгүй байдал, тогтвортой хангамж” уриан дор тэмдэглэн уг чиглэлээр Ерөнхий боловсролын 5 сургуулийн нийт 262 сурагчдад орчноос шалтгаалан хоол хүнс хэрхэн бохирдох, хуванцар савны хэрэглээ, сав баглаа боодол тэмдэг, тэмдэглэгээний тухай сургалт зохион байгуулж, сургуулийн дотуур байр, цэцэрлэг, хувийн цайны газар тогооч, үйлчлэгч, төрийн албан хаагч зэрэг 286 ажилчдад “Хуванцар савны хэрэглээнээс татгалзъя”, “Орчны эрүүл мэнд” хоол хүнс яагаад мууддаг вэ?, хуванцар савны хэрэглээ, хор хөнөөл, хуванцар савны тэмдэглэгээний талаар мэдээлэл хийж, гарын авлага тарааж, гудамж талбай, мэдээллийн самбаруудад байршуулан иргэдэд эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг нийт 3500 хүнийг хамруулан ажиллав.

“Дэлхийн гар угаах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлж, сургуулийн сурагчдын дундах амны хөндийн эрүүл мэнд, гар угаах аргын талаарх мэдлэг дадлыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл өгч, эрүүл зөв дадал эзэмшүүлэх, гар угаах, шүд угаах орчныг үнэлэх ажлуудыг Боловсрол соёл урлагийн газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулж үнэлгээ хийхэд хүүхдүүд гар угаахын ач тус болон гараа хэзээ угаах талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй хэдий ч гар угаах дарааллыг гүйцэд эзэмшээгүй байгаа нь дадал хэвшил болоогүйг харуулж байгаа бөгөөд гар болон шүдээ хэрхэн угаах дадлагжуулах сургалтыг 1795 хүүхдийг хамруулан зохион байгуулж, эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг бий болгоход нөлөөллийн арга хэмжээг авлаа. Мөн энэ үеэр амны хөндийн үзлэгт 2, 3 дугаар ангийн 1844 хүүхдийг хамруулан үзлэг хийхээс 1752 сурагч буюу 95 хувийг хамруулахад 766 буюу нийт хүүхдүүдийн 43,7% нь амны хөндийн өвчлөлтэй байна.

Сум өрхийн Эрүүл мэндийн төвүүд “Цэвэр гар-эрүүл амьдралын жор” сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж нийт 2800 иргэнд мэдээлэл өгч, Эрүүл мэндийн газрын веб хуудасанд гараа угаах шторк, инфографик 16 мэдээлэл, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Жирэмсний хяналтанд эрт орсны ач холбогдол”, “Жирэмсний аюултай шинжүүд”, “Төрөлтөд хэрхэн бэлтгэх вэ?”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, өсвөр үеийн нөхөн үржихүйн эрүүл мэнд” зэрэг сэдвүүдээр мэдээлэл бэлтгэн, долоо хоногийн Пүрэв гараг бүр Ховд ТВ-ээр нэвтрүүлэн мэдээ мэдээлэл иүгээн ажиллалаа.

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийн хүрээнд Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг алслагдсан хөдөөгийн иргэдэд газар дээр нь мобайл технологиор үзүүлж 6-10 саруудад нийт 1076 хүнийг хамруулан төслийн явцын хяналт үнэлгээг төслийн байгууллагаас хангалттай сайн хэрэгжиж байгаа үнэлгээ авав.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд 15-39 насны иргэдэд элэгний В,С вирусийн эрт илрүүлэг шинжилгээг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хийж 2018 оны 10 дугаар сарын 11-ний байдлаар нийт 5100 хүн хамруулж хамралт 16 хувьтай байна. Халдварт өвчний тандалт судалгааг сайжруулан салбарын 23 нэгжээс тандалтын мэдээг нэгтгэн ажилласан бөгөөд 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд 20969 хүн

амбулаториор үйлчлүүлсний 1426 хүн томуу, томуу төст өвчнөөр оношлогдон үүнээс 54 нь амьсгалын замын хүнд халдвартай байв. Нийт бүртгэгдсэн 1426 томуу, томуу төст өвчний 1265 тохиолдлыг 0-15 насны хүүхдийн өвчлөл эзэлж байгаа бөгөөд тарилгатай халдварт өвчний тандалтыг 0-15 насны 7498 хүүхдийн дунд хийж, тандалтаар тарилгатай халдварт өвчин бүртгэгдээгүй болно.

Энэ оны 9 сарын байдлаар 10545 жирэмсэн эмэгтэй хяналтанд байгаагаас 217 эмэгтэйг шинээр жирэмсний хяналтанд авч, эхний гурван сарын буюу эрт үеийн хяналт 89 хувьтай, 1771 эх эсэн мэнд амаржиж, 1776 нярай мэндэлж, гэрийн төрөлт 8 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4 тохиолдлоор нэмэгдсэн, төрөлхийн гажигтай төрсөн 11 хүүхэд бүртгэгдсэн. Аймгийн нийт үзлэг 259434, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 65441 буюу 25,2 хувийг эзэлж байна. Нийт нас баралт 316 тохиолдол эмнэлэгт нас барсан хүний тоо 62 буюу 19,6 хувь, эхийн эндэгдлийн тохиолдол 3 бүртгэгдэж, 100.000 амьд төрөлтөнд 168,9 болж аймаг, улсын дунджаас дээгүүр, нялхсын эндэгдэл 28 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 15,8 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 3 промилээр, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 30 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 20,8 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 1,7 промилээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Халдварт өвчин эхний 9 сарын байдлаар 435 тохиолдол буюу 10000 хүн амд 50,4 буюу өмнөх оны мөн энэ үеэс 2 продицемилээр өссөн байна. Нийт халдварт өвчний 49,4 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 8,2 хувийг сүрьеэ, 20 хувийг салхин цэцэг өвчин тус тус эзэлж байна.

Эмзэг бүлгийн 660 гаруй жирэмсэн эмэгтэйчүүдэд өндөр тунт Д аминдэм хэрэглүүлэх зорилт тавьж 136 хайрцаг буюу 4080 капсул Д3 витамин захиалж, хуваарилан аймгийн хэмжээний 6 сартайгаас 23 сартай хүүхдүүдийн тоон судалгааны дагуу НҮБ-ын Хүүхдийн сангаас хуваарилсан А аминдэм, цайрын бэлдмэл, шингэн сэлбэх уусмалыг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд түгээв.

Эрүүл мэндийн яамны холбогдох мэргэжилтнүүд эрүүл мэндийн тусламжийн чанар, өвчтөний аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг сайжруулах нь сургалт уулзалтыг БОЭТ, Булган сумын нэгдсэн эмнэлэг, 15 сумын эрүүл мэндийн төв, 6 өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч эмч болон Чанарын албаны дарга нар нийт 40 хүнийг оролцуулан зохион байгуулж эмч, мэргэжилтнүүд мэдлэг, мэдээллээ дээшлүүлэх, харилцан сайн туршлагаа хуваалцсан үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Эмийн бодлого, чанар аюулгүй байдал, эмийн хангамжийн чиглэлээр эмийн эргэлтийн сангуудын 2015, 2016, 2017 онуудын борлуулалтын тайлан мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийж, “Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлье” сарын аян өрнүүлж, цахим эмийн жор бичих, В,С вирусийн илрүүлгийн шивэлт хийх нийт 23 эмчид цахим системд нэвтрэх эрх үүсгэн Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтэст хүргүүлэн баталгаажуулж эмч нарт код олгоод байна. 4 дүгээр улирлын тендрийн хуваарийн дагуу 7,1 сая төгрөгийн витамин болон

эмнэлгийн хэрэгслийг сумын эрүүл мэндийн байгууллагуудад түгээж эмийн үйлчилгээг тасралтгүй хүргэж ажиллалаа.

Салбарын төсөв санхүүгийн хувьд 10979,1 сая төгрөгийн эх үүсвэрээр 10588,6 сая төгрөгийн зардалд зарцуулж 247,5 сая төгрөгийн өглөгтэй байгаа нь оны эхнээс 233,9 сая төгрөг буюу 16,8 дахин өссөн байна. Өглөгийн ихэнхи нь 83,5 сая төгрөг нь цалин НДШ-ийн өглөг, 73,5 сая төгрөг нь эмийн өглөг, 33,4 сая төгрөг нь түлш халаалтын өглөг, 23,0 сая төгрөг нь урсгал засварын өглөг, 14,4 сая төгрөг нь тээвэр шатахууны өглөг, 12,8 сая төгрөг нь бичиг хэргийн өглөг 6,4 сая төгрөг нь бусад зардлын өглөг байна.

Анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлгээр 14 сумын эрүүл мэндийн төвд 421,9 сая төгрөг, 6 өрхийн эрүүл мэндийн төвд 45,4 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарийн дагуу олголоо.

Эрүүл мэндийн салбарын хувийн хэвшлийн 64 байгууллагын санхүүгийн орлого, зарлагын тайланг нэгтгэн үзэхэд 1399,4 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1315,7 сая төгрөгийн зардал гаргаж 83,7 сая төгрөгийн ашигтай ажиллав.

Салбарын хүний нөөцийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч эмч, ажилтан нарт 21 хоногийн хугацаанд хууль сурталчлах аяныг зохион байгуулж, хууль эрх зүйн сургалтанд давхардсан тоогоор 361 хүн хамруулсан нь ажилчин албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил боллоо.

Эмчлэх, сувилах эрхийн зөвшөөрлийн шалгалтад хамрагдах эмч, эмнэлгийн мэргэжилтний судалгааг гарган цахим шалгалтыг зохион байгуулж нийт 15 эмч, сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдаж, 1 эмч, 2 сувилагч эрхийн зөвшөөрлөө гардлаа.

Дөрөв: Байгаль орчны чиглэлээр: БОАЖЯ-аас зохион байгуулсан байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах дадал хэвшлийг бий болгох, зөв хандлагыг төлөвшүүлэх зорилготой “Ногоон паспорт-Монгол орон даяар” аян Ховд аймагт нээлтээ хийлээ. Тус арга хэмжээнд аймгийн Жаргалант сумын 7-н Ерөнхий боловсролын сургууль /ЕБС/-ийн “Эко клуб”-ийн 150-иад сурагчдын төлөөлөл болон аймгийн Засаг дарга, Боловсрол, соёл, урлагын газрын дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /БОАЖЯ/-ны төлөөллүүд, аймгийн байгаль орчны салбарын байгууллагуудын мэргэжилтнүүд зэрэг хүмүүс оролцож ногоон паспорт арга хэмжээний талаар мэдээлэл өглөө.

Аяны хүрээнд аймаг, сумын ЕБС-ийн 1000 орчим сурагчдад “Ногоон паспорт”-ыг тарааж, хаягдал зай хураагуур цуглуулах хайрцаг байршуулах ажилд эко клубын багш, сурагчид идэвхтэй оролцож байна. Хүүхэд бүр ногоон паспортын 9 даалгаврыг биелүүлж олсон мэдээллээ бусад хүүхдүүдэд түгээж байгаль орчноо хамгаалах үйлсэд элч болон ажиллах юм.

“Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал” төслөөс зохион байгуулсан байгалийн нөөцийг хамгаалах менежментийн зөвлөлийн үүрэг, журмын хэрэгжилт, журмыг хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хэрхэн хангах талаар хэлэлцэж, хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах зорилго бүхий сургалтыг ТиЭнСи олон улсын

байгууллагатай хамтран зохион байгуулж, сургалтанд оролцогчдод “Байгалийн нөөцийн хамтын менежментийг байгаль орчны төрөөс баримтлах бодлогод тусгасан байдал хэрэгжилт, үр дүн” сэдэвт илтгэл мэдээлэл хийж санал бодлоо солилцлоо. Сургалтанд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Дэлхийн байгаль хамгаалах сан, аймаг, сумдын Бэлчээр ашиглагчдын холбоо, Цаг уур, орчны шинжилгээний төв, Ховд их сургууль, ТиЭнСи олон улсын байгууллагын төлөөлөл, Дарви, Чандмань сумын байгалийн нөөцийн хамтын менежментийн Зөвлөлийн гишүүд 40 гаруй хүн оролцов. ТиЭнСи төслийн зүгээс Дарви, Чандмань сумдын 4 багийн нутаг дэвсгэрт ажиллах байгалийн нөөцийн хамтын менежментийн зөвлөлийн ажиллах журмын төслийг танилцууллаа.

БОАЖЯ, Швейцарын хөгжлийн агентлагийн газар хамтран 2018 оны 10 дугаар сарын 4,5-ны өдрүүдэд Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц, түүний хэрэгжилтийн асуудлаар үндэсний сургалтыг зохион байгууллаа. Тус сургалт, семинарын зорилго нь 2013 онд Монгол Улсад нэгдэн орсон НҮБ-ын “Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц”-иар хүлээсэн үүрэг, түүний хэрэгжилт болон бичил уурхайн үйл ажиллагаа, хууль бус ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаатай холбоотой хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд учруулж байгаа хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэгээ гүнзгийрүүлж, үндэсний хэмжээнд хийгдсэн мөнгөн усны нэгдсэн тооллого, судалгаа болон алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдлыг бууруулах хөтөлбөрийн төслийг хэлэлцлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нэгдсэн үндэсний байгууллага хамтран Завхан аймагт “Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны хохирол тооцох аргачлал” сэдэвт сургалтыг 2018 оны 10 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгуулж Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Архангай аймгуудын Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын уул уурхай, газрын хэвлийн асуудал хариуцсан байцаагч, мэргэжилтнүүд хамрагдлаа.

Дэлхийд нэн ховор цоохор ирвэсийг таньж, мэдэх байгаль экологийн ач холбогдлыг олон нийтэд ойлгуулж мэдрүүлэх, хайрлан хамгаалах үйл хэргийг уриалах зорилготой “Цоохор ирвэсийн өдөр”-ийг “Бид хуулиар хамгаалагдсан” уриан дор 2 үе шаттай зохион байгууллаа. Нэгдүгээр үе шатны арга хэмжээг аймагтаа шалгаруулж, сум аймгийн төвөөс шалгарсан 2 баг Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан нэгдсэн арга хэмжээнд Ховд, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, ОХУ-ын нийт 150 гаруй хүн оролцов.

10 дугаар сарын 13-ны “Бямба” гараг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” тохиосон ба аймгийн хэмжээнд намрын мод тарилтаар 111 аж ахуй нэгж байгууллагын 3160 ажилтан албан хаагчид 11509 мод, 8835 бут сөөг, 12 565 000 төгрөгийн төсвийн хүрээнд нийт 20344 мод, бут сөөгийг шинээр тариалав, Мөн өмнөх жилүүдэд тарьсан мод бутаа арчлах, услах ажлыг зохион байгуулж, ойн мэргэжлийн байгууллагууд иргэдэд мод тарих зөвлөгөөг өгч ажилласан ба аймгийн Засаг дарга,

ИТХ-ын дарга, Жаргалант сумын Засаг дарга нар орон нутгийн телевизээр иргэдээ ойр орчмын талбай, өөрийн хашаандаа мод бут тарьж, тарьсан модоо арчлах, усалгаа хийх зэргээр амьдрах орчноо сайжруулж, орчны бохирдолыг бууруулахад хувь нэмрээ оруулахыг уриаллаа.

БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газар, “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-аас 10 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд аймагт ажиллалаа. Ажиллах хугацаандаа 2013-2015 онуудад байгуулсан ойн зурвасын ажил, мод үржүүлгийн газар, 2018 оны ногоон хэрэм ойн зурвасын ажил болон 2019 онд байгуулах ойн зурвасын зураг төслийн ажилтай танилцаж санал бодлоо солилцож, үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өглөө.

Үенч сумын Үенч гэдэг газар эрэл хайгуулын ажил хийх гэж байгаа Улз Гол ХХК-нд Усны тухай хуулийн 28,4 дахь заалтын дагуу 2018 онд ашиглах усны дүгнэлтийг гаргаж хүргүүллээ. Усны тухай хуулийн 27.1 дахь заалтыг үндэслэн “МоЭнКо” ХХК-ий 2018 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн 01/397 тоот албан хүсэлтийг судлан үзээд Цэцэг сумын Хөшөөт тосгонд унд ахуйн зориулалтаар худаг гаргах зөвшөөрөл олголоо.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дөргөн сумын төвийн ундны усны шинэ эх үүсвэрийг тодорхойлох зорилгоор усны эрэл хайгуулын ажлыг “Алтайн их ус” ХХК хийж гүйцэтгэн тус ажлыг Хар Нуур-Ховд голын сав газрын дарга, мэргэжилтэн, Дөргөн сумын Засаг даргын орлогч, тус сумын байгаль орчны байцаагч, багийн Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүлээж авлаа. Дөргөн сумын төвийн ундны усны шинэ эх үүсвэрийн ажлын хүрээнд шинээр тус бүр 100м гүнтэй 9 ширхэг цооног өрөмдөж 5 цооногийн усны шижилгээ ундны усанд таараагүй, 3 цооногийн усны шинжилгээ цэвэршүүлэн ашиглаж болохоор 3 лабораторын дүгнэлт гарсан ба сумын төвөөс 5 км зайд 30м гүнтэй 7 дугаар цооногийг ундны усанд шууд ашиглаж болохоор дүгнэлт гарсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/71 дугаар захирамж, аймгийн Засаг даргын 2018 оны А/323 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган “Эвдэрсэн газрын тооллого”-ын үр дүн, эвдэрсэн газар тус бүрийн холбогдох мэдээлэл гаргаж, газарзүйн байршлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эвдэрсэн газрын мэдээллийн санд орууллаа.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ний Мянгад сумын нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Цахилгаан түгээх станцын өргөтгөл”, “Хан Жаргалант Ховд” хоршооны Жаргалант сумын нутаг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр” төслүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх холбогдох баримт бичиг материалуудыг судалж байна.

2018 оны 09 дүгээр сарын 24-30-ны өдрүүдэд олон үндэстэн, ястны соёлын биет болон биет бус өв, язгуур урлаг, цайны соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, патентжуулах, өвлүүлэн үлдээх, сурталчлах, аялал жуулчлалаас орох эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор “Цайны зам өв соёлын наадам”-ыг бүх сумд, төрийн

болон төрийн бус байгууллагуудыг хамруулан зохион байгууллаа. Наадмын ерөнхий зохион байгуулагчаар аймгийн Засаг даргын Тамгын газар, хамтран зохион байгуулагчаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам ажиллаа. Аймгийн Засаг даргын 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн А/429 тоот захирамжаар “Цайны зам өв соёлын наадам”-ыг зохион байгуулах ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан наадмыг зохион байгуулах удирдамж, нэгдсэн ажлын төлөвлөгөө, дэд ажлын хэсгүүдийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж ажиллалаа. Наадмын үеэр Тэмээн жин арга хэмжээ, “Адуучин” тэмцээн, Гурван Сэнхэрийн агуйтай танилцах аялал, “Монгол хөөмий” эрдэм шинжилгээний бага хурал, Олон улсын хөөмийн V наадам, Тууль, цуур, бий биелгээ, хөөмий, уран нугаралтын үзүүлбэр тоглолт, Угсаатны цай чанах, патентжуулах арга хэмжээ, “Цайны зам” эрдэм шинжилгээний бага хурал, Уран нугаралтын бэсрэг наадам зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа.

Мөн энэ үеэр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Ховдын хөгжил” үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж, шилдэгүүдээ шалгарууллаа.

Ховд аймагт агаарын бохирдлын хэмжээ жилээс жилд ихсэж байгаатай холбогдуулж аймгийн агаарын бохирдлыг бууруулах аймгийн Засаг даргын 03 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/605 тоот захирамжаар агаарын бохирдуулагчийн эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг хийж, дүн мэдээг нэгтгэн, цахим санд байршуулах чиг үүрэг бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Дүн мэдээг 2018 оны 12 дугаар сарын 15-ний дотор нэгтгэж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/371 тоот тушаалын хүрээнд аймгийн төв, үйлдвэрийн хотхонд РМ10, РМ2.5 тоосонцор хэмжих автомат багажаар тоноглох, агаар болон хөрс, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршгийг бууруулах, дэвшилтэт техник технологийн талаарх хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газарт 200,000,000 төгрөг /хоёр зуун сая төгрөг/-ийн бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлсэн бөгөөд холбогдох мэргэжлийн байгууллагууд хуралдан хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөөд байна.

Францын Рубрук тосгон, “Гийум де Рубрук” холбоо, Арийд олон улсын байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар хамтран гэр хорооллын айл өрхүүдийг боловсон бие засах газартай болгох, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Жаргалант суманд хэрэгжиж буй “Эко бие засах газар байгуулах төсөл”-ийн уулзалт, хэлэлцүүлэг болж, эко 00-ийн хэрэглээ, түүний ашиг тус, үр дүнгийн талаар хэлэлцлээ. Уулзалт хэлэлцүүлэгт аймаг, сумын удирдлагууд болон “Эко бие засах газар байгуулах төсөл”-ийн удирдагч, Франц улсын мэргэжилтнүүд, Ховд их сургуулийн багш, эрдэмтэн судлаачид, байгаль

орчны чиглэлийн байгууллагуудын мэргэжилтэн, Жаргалант сумын 12 багийн эко 00 хэрэглэгч айл өрх, байгууллагын төлөөллүүд оролцов.

Энэ үеэр Жаргалант сумын ундны ус, хөрсний бохирдолтын өнөөгийн төлөв байдал, бохир усны ангилал, бохирдлын төрөл, “Эко бие засах газар байгуулах төсөл”, био хий, бордоо гарган авах төслүүдийн хэрэгжилт, үр дүн, туршилтын явц, хэрэглэгчдийн сэтгэл ханамж, цаашид анхаарах асуудлуудын талаар холбогдох мэргэжилтнүүд мэдээлэл хийлээ. “Эко бие засах газар байгуулах төсөл”-ийн хүрээнд Жаргалант сумын 12 багийн 207 айл өрх болон ерөнхий боловсролын 6 сургууль, Хөгжил Политехник коллежид нийт 263 ширхэг “Эко 00”-ийг үнэ төлбөргүй олгож, Бичигт, Буянт багийн 2 айл өрхөд био хий, бордоо гарган авах туршилт хийжээ. Одоогийн байдлаар сумын айл өрх, сургуулиудад олгосон “Эко 00”-ийн ашиглалт, туршилтын ажил 40 хувьтай байна.

Тав: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор баталсан 54 үндэсний хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан 23 аймгийн дэд хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийг жагсаалтаар гаргаж, хэлтэс, сум, байгууллагуудад албан бичгээр хүргүүлэв.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс тусгах санал боловсруулж, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүллээ.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 бодлого, 14 зорилтын хүрээнд 217 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, аймаг, сум, байгууллагуудын жилийн ажлын төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явцад тайлант онд 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүний үр дүнд төлөвлөгдсөн нийт арга хэмжээнээс 2018 оны 09 дүгээр сарын байдлаар хугацаа болоогүй 3, бүрэн хэрэгжсэн 68, 70 хувийн биелэлттэй 103, 40 хувийн биелэлттэй 34, үнэлэх боломжгүй 2, тасарсан 7 арга хэмжээний хэрэгжилт 72.5 хувьтай байгаа ба 4 дүгээр улирал буюу 2018 оны жилийн эцсийн байдлаар аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт хангалттай сайн хэрэгжих боломжтой байдал харагдаж байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар сум, байгууллагуудаас ирүүлсэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн биелэлтүүд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж сум, байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийг архивлаж, байгууллагын архивт хүлээлгэн өгөхөд бэлэн болгоод байна.

2018 оны 10 дугаар сарын байдлаар Улсын Их Хурлын тогтоол 1, Ерөнхий сайдын захирамж 3, Засгийн газрын тогтоол 45, Засгийн газрын албан даалгавар 1, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал 2, хуралдааны тэмдэглэл 20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VII хуралдааны 4 тогтоол, Тэргүүлэгчдийн 42 тогтоол, 2 хуралдааны тэмдэглэлээс хүлээн авч хяналтын карт хөтөлж, аймгийн

удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Зургаа: Сумдын мэдээлэл:

Зэрэг сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн ээлжит 11 дүгээр хуралдаан 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж, 2018 оны төсвийн тодотгол болон холбогдох 5 асуудал хэлэлцлээ. Мөн төсөвт байгууллагууд болон суманд үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨААТҮ-ийн газрын ажилтай танилцаж тэдний санал бодлыг сонсов. Сумын төвийн гэрэлтүүлгийн шон, гэрэл, цахилгааны утасны бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, шаардлагатай засваруудыг Тамгын газрын албан хаагчдын оролцоотойгоор засвар үйлчилгээг хийлээ.

Сумын дулааны “Тээлийн илч” ОНӨААТҮГ, айл өрхүүдийн хэрэгцээт түлээ нүүрсний захиалгыг баг бүрээр авч нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ хийж, нүүрсний татан авалт хийгдэж байна. 2018 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар нунтаг нүүрсний татан авалт 800тн буюу 70 хувьтай байна. Сумын төвд оршин суудаг айл өрх тус бүрт 2 тн нүүрс, мал аж ахуйн багийн айл өрхүүдэд 1тн нүүрсний эрхийн бичгийг МоЭнКо ХХК-аас авч олгосон бөгөөд айл өрхүүдийн 70 гаруй хувь нь хэрэгцээт нүүрсээ татан авсан.

2018-2019 оны өвөлжилт хаваржилт хөдөө аж ахуйд тэр тусмаа мал аж ахуйд хүндрэл учрах нөхцөл байдал үүсээд байгаа тул Завхан аймгийн Цагаанхайрхан, Цагаанчулуут, Говь-Алтай аймгийн Жаргалан, Хөхморьт, Баян-Уул, өөрийн аймгийн Мянгад, Манхан, Алтай, Үенч, Мөнххайрхан, Дуут, Цэцэг, Мөст, Чандмань сумдад мал сүргээ оторлон өвөлжүүлэхээр 37 өрхийн 12251 толгой мал өвөлжиж, хаваржих бэлтгэл хангаж байна.

Мал сүргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 102024 толгой мал, угаалгад 10150 толгой мал, туулгалтад 21600 толгой мал тус тус хамрагдсан. Мал сүргийг эрүүлжүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахын зэрэгцээ 75 хашааны 12656м² талбайг суперкилл, экокцид, хлорын шохой зэрэг бодисуудаар халдваргүйжүүлэлт хийгдэв. Бог малыг мялзан төст өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциний тарилга хийж, 51000 толгой мал хамрагдаад байна.

Бог малын хээлтүүлэгч малыг нийлүүлгийн бус үед үндсэн сүргээс ялган суурилах ажлыг зохион байгуулсан ба 2018 оны жилийн эцсийн улсын мал тооллогоор ингэ 772, гүү 2155, үнээ 3639, эм хонь 30993, эм ямаа 41696, бүгд 79255 толгой хээлтэгч, буур 19, азарга 271, бух 123, хуц 408, ухна 549 бүгд 1370 толгой хээлтүүлэгч малыг тоолж бүртгэлжүүлэв.

Олон улсын багш нарын баярын өдрийг тохиолдуулан ажил үйлсээрээ манлайлсан албан хаагчдыг шагнаж урамшуулан Бүжинхэн хүүхдийн цэцэрлэгийн Тэргүүний цэцэрлэгийн шагналыг сумын удирдлагууд гардуулан баяр хүргэж амжилт хүсэв.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 63 тоот зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Мод тарих үндэсний өдөр”-өөр ард иргэдийг уриалан сумын төвийн төгөл модонд 160 ширхэг чацаргана суулгац тарив.

“Элэг бүтэн монгол” үндэсний 2 дахь шатны хөтөлбөрийн хүрээнд 15-39 насны 1368 иргэн хамрагдахаас, 392 иргэн шинжилгээнд хамрагдав.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, 32, 258 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 08 дугаар албан даалгавар, сумын Засаг даргын 89 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, хариуцлагатай, ил тод, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх ажлын хүрээнд төсвийн байгууллагуудад хяналт шалгалт хийж, төрийн албан хаагчдаас Төрийн албаны болон Хөдөлмөрийн тухай хуулиудаар хууль эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтоов.

Үенч сум: “Цайны зам” өв соёлын наадамд захчин сумдаа төлөөлөн цагаан идээ, гар урлал, эсгий урлал, аргамж дээс, сармис, эрдэнэшишийн ургамалаар үзэсгэлэнд амжилттай оролцож аймгийн Засаг даргын Батламж гардан авсан.

Олон улсын ахмадын баяраар сумын ахмадын холбоотой хамтран ахмадуудад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа.

Сумын номын сан нь уншлагын танхимаар нийт 22 уншигчдад 30 ширхэг ном олгож үйлчлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 63 тоот зарлигийн хэрэгжилтийг хангаж “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрөөр төсөвт албан байгууллагууд хамтран сургуулийн дотуур байрны доод урд талбай, заалны хажуу талын саад, соёлын төвийн гадна талбай, төв цэцэрлэгт хүрээлэнд хайлаас, улиас нийт 2000 ширхэг мод, бут тарив.

Монголын багш нарын баярыг угтаж ахлах, дунд ангийн сурагчдын дунд “Би багш бол” сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, бага ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, багш нарын дунд “Сайн хичээл”-ийн үйл ажиллагаа, илтгэлийн уралдаан, багш, ажилчдын дунд “гар бөмбөг”-ийн тэмцээн тус тус зохион байгуулж, эхний 3 байр эзэлсэн баг тамирчдыг медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Сургуулийн номын сангаас зохион байгуулж буй “Ган үзэг-2018” яруу найраг, их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит “Шувуун саарал-2018” богино өгүүллэгийн уран уншлагын наадмыг монгол хэл, уран зохиолын багш нартай хамтран 1-12 дугаар ангиудын дунд 3 үе шаттайгаар зохион байгуулж нийт 104 сурагч оролцож оюун ухаан, авьяас чадвараа сорьж шилдэгүүдээ шагнаж урамшууллаа.

Сургалтын менежерүүд багш нар 7 хоног бүрээр сургалтын төлөвлөгөө батлуулан хэрэгжилтэнд сургалтын менежер хяналт тавин ажиллаж байна. Бага ангийн суралцагчдын зөв дадал хэвшил эзэмшиж байгаа байдалд тусгай шалгуур тавьж мөрдөн ажиллаж байна.

Сургууль, дотуур байрны сурагчдын хүнсний хэрэгцээнд тариалангийн талбайд 3 тонн төмс, хүнсний ногоо, 300 кг тариа тарьсан, хураан авч нөөцлөв. Сургуулийн халаалтын бүрэн бүтэн аюулгүй байдлыг ханган халаалтын системийг засварлаж, нүүрс гэрээлэгч байгууллагатай 150 тонн нүүрсний гэрээ хийж татан авч байна.

Сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа хэвийн, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох ажлын хэсэг ажиллаж 65 хүний групп сунгалт хийв. Дэлхийн гар

угаах өдрийг тохиолдуулан “Цэвэр гар- эрүүл амьдралын жор” сэдвийн дор ажлын төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу “Гар цэвэр бол бие эрүүл”, гар угаах дарааллын зурагт хуудсуудыг зарын самбар олон нийтийн газар байршуулан мэдээлэл түгээв.

Эрүүл мэндийн төвийн эх баригч эмч цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд “Бидний гар-Бидний ирээдүй” сэдэвт сургалт мэдээлэл хийв. Явуулын эрүүл мэндийн тусламжийн баг хөдөөгийн 4 багийн иргэдэд үзлэг, оношилгоо, элэгний В,С вирусийн илрүүлэг шинжилгээ хийж ажиллав.

Манхан сум: Сумын ЗДТГ-ын удирдлагууд Ботгон, Улаанхүрээ багийн иргэдийн нийтийн хуралд оролцож цаг үеийн мэдээ, 2018 онд хийсэн ажил, цаашид хийгдэх ажлууд болон өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар мэдээлэл хийж, иргэдийн санал хүсэлтийг сонслоо.

Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагууд нэгдсэн төвлөрсөн халаалтанд холбогдож байгууллагууд хэвийн халж байна.

Хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг зохион байгуулж 9 цэрэг цэргийн албанд татагдсан.

“Зохистой хөдөлмөр, хөдөлмөрийн бүтээмж” аяны хүрээнд аймгийн Үйлдвэрчний эвлэлээс зохион байгуулсан “Харилцаа, ёс зүй, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сургалтанд байгууллагуудын албан хаагчдыг хамруулж тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүллээ. Мөн “Цэвэр орчин” аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээг зарлан, булаг шанд, усны эх, нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэж хог хаягдлыг хогын цэгт устгав.

“Хуулиа дээдлэе, мөрдье” аяны хүрээнд бүх шатны төрийн албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хөдөлмөрийн тухай хуулиар сургалт зохион байгууллаа.

Монголын багш нарын өдрийг угтан сургуулийн захиргаанаас тусгай хөтөлбөрийн дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: нийт багш нарын дунд “Би бол багш” эсээ бичлэгийн уралдаан, Заах аргач зэрэгтэй ахлах, дунд ангийн багш нарын дунд “Мэдээлэл харилцааны технологийг сургалтанд ашиглах нь” цахим хичээлийн уралдаан, эцэг эхчүүдийн дунд “Багшийн хөгжил” эсээ, сурагчдын дунд бүтээлч санааны уралдаан, волейбол, теннисний тэмцээн, 12 дугаар ангийн сурагчдын дунд “сурагчдын нэг өдөр”, “Эх хэл эрдмийн түлхүүр” сэдэвт уулзалт ярилцлага, спорт урлаг, танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулж багш, эцэг эх, олон нийтийн оролцоог идэвхижүүлж хамтын ажиллагааг өрнүүллээ.

Хичээлийн заах аргыг сайжруулах, сайн туршлага, арга технологийг нэвтрүүлэх замаар багш нар өөрсдийн заах судлагдахуун бүрээр заах аргын нэгдлээрээ хамтран хичээлийн судалгаа анализ хийсэн. Энэ хүрээнд ахлах ангийн 8, бага ангийн 5 төрлийн судлагдахуунаар хичээлийн судалгаа хийж хэлэлцүүлэн сайжруулаад байна.

Сумын Соёлын төв олон улсын ахмадын өдрөөр хөдөөгийн багийн ахмадуудын дунд дуу бүжиг, хөзөр, шатрын тэмцээн зохион байгуулж хүндэтгэл үзүүлсэн.

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын соёлын ажилтнууд ирж харилцан туршлага солилцож түүх соёлын дурсгалт газраар аялан хамтарсан тоглолт, цэнгүүн зохион байгуулж хамтач ажиллагааг өрнүүллээ.

Сумын Хүүхдийн цэцэрлэг сахилга хариуцлагыг чангатгах ажлын төлөвлөгөө боловсруулан хамт олны хурлаар хэлэлцүүлж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн хороо, багш нарын зөвлөл, дотоод хяналтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр шуурхай зөвлөгөөн хийж 2018 онд хийсэн ажил цаашид хийгдэх ажлын мэдээлэл солилцов. Энэ хүрээнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх, ажилтнуудын ажлын ачааллыг жигдрүүлэх, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах, тус өөрчлөлтийг ажлын байрны тодорхойлолтонд тусган ажиллах, жижүүр багшийн ажлын чиг үүрэгт шинэ ажлууд тусгах түүнийг хэрэгжүүлж ажиллах талаар мэдээлэл хийж санал бодлоо солилцов. Мөн өдөр тутмын цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах, цагийн бүртгэлийн хяналтыг эрчимжүүлэх, долоо хоногийн сургалт, үйл ажиллагаанд заах аргын нэгдлийн ахлагч нар хуваарийн дагуу сууж зөвлөн туслах, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд гал зуухны агааржуулагчийн хоолой бусад бэлтгэл ажлуудыг хийж дуусгахыг холбогдох ажилтнуудад удирдлага үүрэг болгов БСУГ-аас ирүүлсэн мэдээллийн системийн болон бусад хугацаат мэдээг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Сумын Эрүүл мэндийн төв 3 их эмч, 21 ажилтан, нийт 24 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. 2018 оны 10 дугаар сарын 26-ны байдлаар 356 үйлчлүүлэгчдэд амбулторын үзлэг шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх үзлэгт 128 хүн хамруулсан ба эмнэлэгт 42 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн шинжилгээнд зорилтот бүлгийн 6 иргэнийг хамруулав. Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 54 хүүхэд, нэмэлт дархлаажуулалтанд 96 хүүхэд хамрагдсан. 3 эх эсэн мэнд амаржуулж, алсын 7 удаагийн дуудлаганд үйлчилж ажиллав.

Томуу томуу төст өвчний тандалтын мэдээг 7 хоног бүр холбогдох байгууллагад хүргүүлсэн ба 0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна.

Монгол мал хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээний 147.0 мянган төл малыг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулж гүйцэтгэлийн тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллав.

Дуут сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2 удаа хуралдаж, 4 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн.

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраас дараахь ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг ахмадын баярыг 10 дугаар сарын 01-нд тэмдэглэн өнгөрүүлээ. Уг үйл ажиллагааны хүрээнд сумын нийт ахмадуудад урилга

хүргүүлж уулзалт, хүлээн авалтыг зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд нийт 70 гаруй ахмад оролцлоо. Төрийн байгууллагад ажиллаж байгаад насны тэтгэвэртээ гарсан ахмадуудад албан байгууллага бүр гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлсэн.

10 дугаар сарын 05-ны өдөр олон улсын багш нарын 52, монголын багш нарын 24 дэх баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн. Тус баярын арга хэмжээнд сумын ахлах сургууль, цэцэрлэгийн 50 орчим багш хамрагдав. Баярын өдөр БСШУС-ын яамны шагнал, аймаг, сумын Засаг дарга, аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, аймаг, сумын ИТХ-ын даргын нэрэмжит шагналуудаар 12 багшийг шагнаж урамшуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн 05, 10 дугаар сард бүх нийтээр мод тарих ажлыг өрнүүлдэг уламжлалтай. 10 дугаар сарын 11-ний өдөр сумын ЗДТГ-ын ажилчин, албан хаагчид шинээр байгуулагдсан туульсын өргөөний хашаанд 320 ширхэг хайлаас мод тарив. 1985 оны төгсөлтийн хамт олны санаачлагаар туульсын өргөөний хашааг цэцэрлэгт хүрээлэн болгохоор шийдвэрлэв.

2018 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагад 20 залуу хамрагдаж 6 залуу цэргийн албанд тэнцэн холбогдох цэргийн ангиудад хуваарилагдсан.

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн ажлын хэсэг, сумын татварын байцаагч, эрх зүйн ажилтан нарын бүрэлдэхүүнтэйгээр дэлгүүр үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийж, архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл бүхий 7 дэлгүүрт шаардлагын дагуу хяналт шалгалт хийж аттетстачлалд хамрууллаа. Тус шалгалтаар 85 ба түүнээс дээш оноо авсан 5 дэлгүүрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж үйл ажиллагааны зөвшөөрлийг сунгахаар шийдвэрлэв.

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажил 10 дугаар сарын 22-ны өдрөөс 10 хоногийн хугацаанд үргэлжлэх ба тус вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилон ажиллаж байна. Хөх бэлчир багт “Дуут дунд цэнхэр” МЭҮНэгж 68200 толгой бог малд, Шивэр багт “Нуурт оч” МЭҮНэгж 67400 толгой бог малд, Цагаанбургас багт “Ариун нуур” МЭҮНэгж 53300 толгой бог малд нийт сумын хэмжээгээр 188900 толгой бог малд мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин хийгдэх юм.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/21 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган сумын төсөвт албан байгууллагууд гадна болон дотор хяналтын камер суурилуулаад байна.

Сумын Эрүүл мэндийн төвөөр 21 иргэн хэвтэн эмчлүүлж, 10 иргэнийг өдрийн эмчилгээгээр эмчилж, 3 эхийг эсэн мэнд төрүүлж, 21 эхийг жирэмсэн эхийг хяналтанд авч, алсын дуудлагад 10 удаа явж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэв. Эмч Б.Ариунжаргал, НЭМА Д.Мөнх-од нар ЕБС-ийн 1-5 дугаар анги, цэцэрлэгийн ахлах, дунд, бага бүлгийн хүүхдүүдэд “Амны хөндийн эрүүл ахуй”, “Гараа хэрхэн зөв угаах вэ” сэдэвт сургалт зохион байгуулж амны хөндийн үзлэг хийхийн зэрэгцээ цэцэрлэг, сургуулийн нийт 160 хүүхдэд шүдний эрүүл мэндийн үзлэг хийсэн. Сургуулийн нийт 103 хүүхэд үзлэгт хамрагдсаны 79 хүүхэд буюу нийт

хүүхдийн 76,7% нь шүдний цооролтой байсан бол цэцэрлэгийн нийт 57 хүүхэд хамрагдсаны 24 хүүхэд буюу нийт хүүхдийн 43,2 хувь нь шүдний цооролтой байв.

Ерөнхий боловсролын сургуулийн 7, 15 настай хүүхдүүдийг сахуу, татрангийн вакцинд хамруулав.

“Хүнсний аюулгүй байдлыг хангахад-Иргэн таны оролцоо” аяны хүрээнд “Үдийн цай” нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын хамт Мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан сургалтад оролцож, “Үдийн цай”-ны гурвалсан гэрээг шинэчлэн байгууллаа.

Сургууль болон хүүхдийн хөгжил төлөвшилд дэмжлэг үзүүлэх зорилгоор төр, төрийн бус байгууллага, ААН байгууллагууд боловсролын байгууллагатай хэрхэн уялдаа холбоотой хамтран ажиллах чиглэлээр зохион байгуулагдсан нэгдсэн зөвлөгөөнд Сумын Засаг дарга, эцэг эхийн төлөөлөл, багш, удирдлагын төлөөлөл оролцов.

Монголын багш нарын баярыг угтан зохион байгуулсан “Багшийн хөгжил-2018” аяны хүрээнд эцэг эхчүүд, олон нийтийн дунд “Би багш бол” эсээ бичлэгийн уралдаан, сурагчдын дунд фото зургийн уралдаан, заах аргач багш нарын дунд бүтээлч санааны уралдаан, “Тэргүүлэх зэрэгтэй багш нарын манлайлал” 7 хоногийн аян, цахим хичээлийн багийн уралдаан тус тус зохион байгуулав. 2017-2018 оны хичээлийн жилд аймгийн “Шилдэг үнэлгээтэй сургууль”-иар шалгарсан амжилттай ажиллав. Энэ хүрээнд хамт олноо манлайлан ажилласан тэргүүний багш ажилчдаа шагнаж урамшуулав.

Хүүхэд багачуудын математик сэтгэлгээ, өгүүлбэртэй бодлого бодох чадварыг хөгжүүлэх, багаар ажиллах чадварт сургах, математикийн хичээлд сонирхолтой болгох зорилгоор “Тэмүүлэлтэй математикчид” анги нийтийн онлайн олимпиадын 1 дүгээр шатны шалгаруулалтыг амжилттай зохион байгуулав.

Эх хэлний чадварыг дээшлүүлэх зорилгоор 1-5 дугаар ангийн сурагчдаас 14 хоногт нэг удаа цээж бичлэгийн шалгалт авч, сайжруулахад анхааран ажиллахын зэрэгцээ массын олимпиадад амжилттай оролцох зорилгоор хүүхэд нэг бүрийн ахиц амжилтыг тооцон нэмэлт давтлага өгч ажиллаж байна.

Багш нарын мэдээлэл технологийг оновчтой ашиглах, ажиллах чадварыг сайжруулах, ажлын байрандаа хөгжих бололцоог нэмэгдүүлэх, багийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор багш нарын дунд цахим хичээлийн уралдаан зохион байгуулав.

Аймгийн Нийтийн номын сангаас жил бүр зохион байгуулдаг “Ган үзэг-2018”, “Шувуун саарал” наадмын 1, 2 дугаар шатны уралдаанд сургуулийн сурагчид оролцож, “Шувуун саарал” наадамд 1а ангийн сурагч Г.Анар 3 дугаар байр эзэлж Гран при шагналын төлөө өрсөлдөх эрхийн эзэн болов. Мөн 2018 оны ширээний теннисний аймгийн аварга шалгаруулах тэмцээнд сурагч Б.Энхзаяа хос хүрэл, Ш.Мөнхцэцэг хос хүрэл, Э.Сувд-Эрдэнэ мөнгө, Э.Сарангарав мөнгөн медаль хүртсэн амжилттай оролцов.

Олон улсын гамшгийн эрсдлийг бууруулах өдрийг угтаж сурагчдын дунд зохион байгуулсан “Гамшгийн эрсдлийг бууруулахад хүүхэд залуучуудын оролцоо” сэдэвт видео бичлэгийн уралдаанд Н.Анхбаяр ахлагчтай сурагчдын бүлэг амжилттай оролцож, улсад 1 дүгээр байр эзлэв.

БСШУС-ын сайдын 2018 оны А/608 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам”-ын дагуу эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэн журмын хэрэгжилтийг хангах чиглэлд төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/21 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган сургуулийн хичээлийн байранд камержуулалт суурилуулав.

Сумын Хүүхдийн цэцэрлэг БСШУС-ын яам, аймгийн БСУГ, цэцэрлэгийн 2018-2019 оны хичээлийн жилийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 12 заалт бүхий төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу эцэг эх байгууллагын хамтын ажиллагааг нягтруулах нээлттэй үйл ажиллагааг 1 удаа, нээлттэй хаалганы өдрийг 1 удаа тус тус зохион байгуулж тус арга хэмжээнд нийт 48 эцэг эхчүүд оролцов.

СӨБ-ын статистик мэдээг 19 төрлөөр гаргаж хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүллээ. Хамран сургах тойргийн нийт 197 хүүхдээс үндсэн бүлэгт 89, явуулын сургалтанд 63 бусад аймаг сумын цэцэрлэгүүдэд 26 хүүхэд хамрагдаж хамран сургалт 88,3%-тай байна.

“Чадварлаг Ховд” хөтөлбөрийн хүрээнд сумын удирдлагууд, сургууль, цэцэрлэг хамтарч болор цомын эзэн яруу найрагч М.Отгонбаярын алдрыг тэмдэглэх, хүүхэд багачуудад уулзалт, ярилцлага хийх, яруу найргийн наадам зохион байгуулахын зэрэгцээ цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн дунд тухайн суманд сумын харьяат болор цомын эзэн яруу найрагч Х.Эрдэнэбаатар, М.Отгонбаяр нарын шүлгийг “Хэн сайн унших вэ” тэмцээн зохион байгуулахад 4-5 насны нийт 16 хүүхэд оролцож бэлтгэл бүлгийн сурагч А.Намуунбайгаль тэргүүн байр эзэллээ.

Хүүхэд бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааг тогтмол чанартай зохион байгуулж “Жимс, жимсгэнэ” сэдвээр нээлттэй үйл ажиллагаа, хөгжүүлэх үйл ажиллагаанд 41 эцэг эхийн төлөөллийг оролцуулж, тэдний санал хүсэлтийг сонсов.

Багш, ажилчид соёлтой харилцааг эрхэмлэн ажиллахын зэрэгцээ хүүхдүүд, эцэг эхчүүдтэй өглөө бүр мэндлэх, хүүхэд бүрийг бие биетэйгээ, багштайгаа мэндэлж сурах энгийн бөгөөд хэл яриа, харилцааны чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг тогтмол явуулж хэвшлээ. Хүүхэд бүрийг хөгжүүлэхэд байгууллагын ажилтан бүрийг оролцуулах, тэдний оролцоо, идэвхийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.

Байгууллагын төсвийн зарцуулалтыг сар бүр самбарт байршуулан иргэдэд нээлттэй мэдээлж байна.

Дөргөн сум: Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан сумын өндөр настан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлж, сумын ахмадын хорооны 2018 оны ажлын тайлан, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тухай хууль орон нутгийн цаг үеийн мэдээлэл өгч сум орон нутагт олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрлөсөн

ахмад настнуудыг аймгийн ИТХ-ын хүндэт өргөмжлөл, Засаг даргын шагналаар шагнаж урамшуулав. Тус баярын арга хэмжээнд сумаас аймгийн ИТХуралд сонгогдсон төлөөлөгч П.Улаанхүү 500000 төгрөг, 165 ахмадад гарын бэлэг, бизнес эрхлэгч Д.Төртүвшин 80-аас дээш 14 ахмадад гарын бэлэг, Улаанбаатар хотын нутгийн зөвлөлийн гишүүн Д.Цагаанцоож 50000 төгрөг, Хаан банкны салбар 100000 төгрөг, Төрийн банкны салбар 50000 төгрөгийг хандивлаж, багийн Засаг дарга нар үдийн зоог, албан байгууллагууд тэмцээн уралдааны шагналуудыг ивээн тэтгэж амжилттай зохион байгууллаа.

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тэргэнцэр 2, нүдний шил 51, суултуур 11, нурууны бүс 25, бөөрний даруулга 20, 16ш хүзүүвчийг хөнгөлөлттэй үнээр авах захиалга хүргүүлж нийт 71 ахмадад олголоо.

Сум орон нутгийнхаа үндэстэн угсаатны түүх соёл, зан заншил, өв уламжлал, угсаатны гаралтай эд өлгийн зүйлийг сурталчлах, нуугдмал авъяастан, үнэт өв, мартагдсан урын сан, хэв ёсыг нээн илрүүлж, нийтийн хүртээл болгон хөгжүүлэх зорилготой “Сум сурталчлах өдөр”-ийг 10 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгууллаа. Өдөрлөгөөр “Дөрвөд түмний дуун цацал” 40 хүний бүрэлдэхүүнтэй тайлан тоглолт, Дөрвөд угсаатны эд өлгий, нутгийн алдартнуудын фото зураг, түүхийн үл хөдлөх дурсгалын гэрэл зураг, нутгийн зохиолчдын ном, гар урчуудын бүтээл, угийн бичиг, цагаан идээ, брэнд бүтээгдэхүүн зэрэг 7 төрлийн үзэсгэлэн гаргаж, сумын гэр музейн 62 төрлийн үзмэрийг олон нийтэд дэлгэн үзүүлсэн. Энэ хүрээнд аймгийн Засаг даргын хүндэт өргөмжлөлөөр 2 албан хаагч, жуух бичгээр мөн 2 албан хаагч, БСУГ-ын “Шилдэг сурагч” медалиар 3 сурагч, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын “Шилдэг хүүхэд” медалиар шилдэг 4 сурагчийг шагнаж өргөмжлөв.

“Миний Ховд 2018” язгуур урлагийн анхдугаар наадам арга хэмжээнд дөрвөд угсаатны язгуур урлаг болох бие биелгээ, хөөмий, ерөөл магтаал, уртын дуу, ардын хөгжим, дууны төрлөөр сум 10 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай оролцов.

Сумын төсөвт албан байгууллагуудад мах нүүрс нийлүүлэх ажлын тендр шалгаруулалт зарлуулж, тендерт сумын иргэн Б.Мөнхбат хотгорын нүүрсийг 79500 төгрөгөөр, тарвагатайн нүүрсийг 69500 төгрөгөөр нийлүүлэхээр, Махны тендерт иргэн Б.Төмөрхуяг хонины мах 5000, үхрийн мах 3500, ямааны мах 3000, тэмээ, адууны махыг тус бүрийг нь 2500 төгрөгөөг нийлүүлэхээр тус тус шалгарсан.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар засварлагдсан Агваш багийн Чаргатын их худаг, Сээр багийн Баян овоон хойд худаг, Баянхайрханы урьд худаг, мал угаалгын ванн, Аргалант багийн Хондлойн худгийн засварын гүйцэтгэлийн явцад хяналт тавин ажиллаж, ажлын хэсэг газар дээр нь ажиллалаа.

Сумын засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/16 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан бог малыг Мязан өвчний вакцинжуулалтанд бүрэн хамруулахаар ажиллаж, 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар Агваш багийн 9 өрхийн 1342 хонь, 122 хурга, 3877 ямаа, 545 ишиг, нийт 5886 бог мал, Аргалант багийн 9 өрхийн 1010 хонь, 117 хурга, 2640 ямаа, 186 ишиг буюу нийт 3953

бог мал сумын дүнгээр 18 өрхийн 2352 хонь, 239 хурга, 6517 ямаа, 731 ишиг нийт 9839 бог малыг вакцинжуулалтанд хамруулсан, 1200 тн байгалийн хадлан, 220 тн гар тэжээл, 330 тн хужир шүү бэлтгэж сумын аюулгүй нөөцөд 35.5 тн өвс, 1 тн тэжээл бэлтгэсэн дүн мэдээтэй байна.

Хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийх графикт удирдамжийн дагуу ажлын хэсэг тусгай зөвшөөрөлтэй 6 дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт хийж, шалгалтын явцад ямар нэг зөрчил дутагдал илрээгүй болно.

Аргалант багийн Хөх эргийн аарагт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн нөлөөгөөр эвдрэлд орсон 3,5 га нөхөн сэргээлт хийсэн талбайд иргэд орж буй мэдээллийн дагуу Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагчид хяналт шалгалтаар ажиллахад тус газарт хөндөгдсөн болон шороо угаасан зөрчил гараагүй байв.

2018 оны тайлант сард нийт 368 тэтгэвэр авагчдад 107728,6 мян төгрөгийн санхүүжилтээр тэтгэвэр олгосон ба өндөр насны тэтгэвэр авагч 272, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 34, тахир дутуугийн тэтгэвэр авагч 62, шинээр 3 өндөр настанд тэтгэвэр тогтоосон. Сайн дурын даатгалд нийт 64 даатгуулагчийн 3059,3 төгрөг, төсвийн байгууллага болон ААН-үүдээс нийт 29472,7 мянган төгрөгийн шимтгэлийн орлого тус тус төвлөрүүлсэн. Шинээр 5 даатгуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулж ажилласан. Эрүүл мэндийн даатгалд 26 хүний 1056,4 мянган төгрөгийн орлого оруулсан ба тэтгэмжийн даатгалын сангаас оршуулгын тэтгэмж 1 хүнд 1 сая төгрөг, жирэмсэн амаржсны тэтгэмж 1 хүнд 754,6 мян төгрөгийн тэтгэмж, 1 хүнд оршуулгын тэтгэмжид 1000,0 сая төгрөг, 1 хүнд ЖА –тэтгэмжид 754,6 мян төгрөгийн тэтгэмж тус тус олгосон.

Хөдөлмөр нийгмийн халамжийн сангаас ахмад настны асаргаа 61 хүнд 4.270,000 ХБИ-ний асаргаа 19 хүнд 1.330.000, ХБХ-ийн тэтгэвэрт 8 хүүхдэд 1.240.000, халамжийн тэтгэвэр 40 хүнд 6.200.000, тэжээгчээ алдсны тэтгэвэр 15 хүнд 2.325.00, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 44 өрх 3144000 төгрөгийг тус тус олгов.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаг 44 өрхөөс сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэл тайлан мэдээг ХХҮГ-т хүргүүлэв.

Бэлчээрийн идэгдэцийн байдал, өнгөн хөрсний нүүдэл шилжилтийн байдал, ургамлын төлөв байдал, ургац идэмж даацыг тодорхойлох фотомониторингийн судалгааг сумын нутаг дэвсгэр дэх 12 цэгийг зурагжуулан авсан. Мөн сумын бүс бүслүүрийг тодорхойлж, хөрвүүлсэн файлаа Ланд менежер программд шивж, сумын фотомониторингийн цэгийг баталгаажуулж мэдээллийн сан үүсгэсэн. Хамтран өмчлөгчөө салгуулахыг хүссэн 1 иргэний өргөдлийг хүлээн авч холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэв. Өвөлжөө, хаваржаны гэрчилгээ авах хүсэлтэй 4 иргэнээс хүсэлт ирсэнээс багийн иргэдийн нийтийн хурлаар батлагдсан нэрсийн дагуу 3 иргэнд гэрчилгээ олгож, газар өмчлөхийг хүссэн 5 иргэний өргөдлийг хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлэн мэдээллийн сан үүсгэсэн. Хүүхэд бүрийг алдаагүй, цэвэр сайхан бичдэг болгох, цэвэр бичигтэн сурагчийг

шалгаруулах зорилгоор “Цэвэр сайхан бичигтэн” сарын аяны удирдамж боловруулан хэрэгжүүлж, дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- “Цэвэр бичигтэн анги” 1-5, 6-12 дугаар анги гэсэн 2 насны ангиллаар зохион байгуулж, цаашид анхаарах асуудлын талаар санал бодлоо солилцов.

- “Цэвэр бичигтэн багш” уралдаан зарлаж 34 багш оролцож шилдэг цэвэр бичигтэн багш шалгаруулав.

- “Алдаагүй бичдэг анги” уралдаанд 23 бүлгийн 522 сурагчаас цээж бичиг авч анализ хийж сурагчдыг 8 түвшинд хуваан цаашид хоцорсон сурагчидтай ажиллах ажлын чиглэлтэй болов.

- “Чадварлаг Ховдчууд” хөтөлбөрийн хүрээнд сурагчдыг ном унших сонирхолтой болгох, тэмдэглэл хөтлөх арга барилд сургах, тодорхой зохиолыг хугацаатай унших даалгавар өгч “Уншихаа боливол сэтгэхээ болино” аян өрнүүлж, ажиллах удирдамж боловсрууллаа.

- Сурагчдын унших чадварыг тодорхойлох зорилгоор 520 сурагчаас “Минутын уншлага” авч цаашид яаж ажиллах ёанал солилцов. Багш нарын баярын хурлыг Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж хамт олноо хошуучлан манлайлж ажилласан тэргүүний багш нараа шагнаж урамшууллаа. Энэ хүрээнд “Сурагчийн нэг өдөр” зохион байгуулж, 34 багш СНА, сургалтын менежер, захирлуудын ажлыг 39 сурагч хариуцан багшийн нэг өдрийн ажилтай танилцан сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг зохион байгуулж явууллаа.

БСШУЯ-ны боловсролын үнэлгээний төвөөс бага боловсролын түвшинд үнэлгээ хийх чиглэл өгч, түүврийн аргаар 2а ангиас 15 сурагч, 1б ангиас 15 сурагч сонгон авч уншлагын түвшин тогтоох шалгалт авав.

“Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд бага ангийн номын санд зориулан 4.188.700 төгрөгийн үлгэрийн ном захиалав.

“Хөдөлгөөн эрүүл мэнд” аяны хүрээнд спортын авьяаслаг сурагчийг тодруулах, хамт олонч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор “Спортын бага наадам”-ыг бага, дунд , ахлах 3 насны ангиллаар зохион байгуулж шилдгүүдээ тодрууллаа.

Багш, ажилчдын ёс зүй харилцааны боловсролыг дээшлүүлэх чиглэлээр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймгийн ҮЭХ-ны сургагч багш нар 47 төрийн албан хаагчдад “Ёс зүй ба харилцаа”, “Хөдөлмөрийн хууль” “Хөдөлмөрийн аюулгүй байдал” сэдвийн хүрээнд мэдлэг ойлголт өгөв.

Сумын Эрүүл мэндийн төв ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Тайлант сард амбулатороор 140 хүн үйлчлүүлсэн. 10 удаа алсын дуудлагад явж, 19 өвчтөнийг хэвтүүлэн эмчилсэн.

Эх хүүхдийн ноцтой хүндрэл гарахаас урьдчилан сэргийлж жирэмсэн эхийг цаг тухайд нь хяналтанд авч, эх хүүхдийн эндэгдэл гаргаагүй болно.

Сумын Номын сангийн үйлчилгээг сурталчлах, сурагчдыг ном унших дур сонрхолтой болгох, номоор хүмүүжүүлж, төлөвшүүлэх зорилгоор 10 сарын 01-нээс 20-ний өдрүүдэд ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд “Бүтээлчээр уншъя” ном уншлагын аян өрнүүлж, тус арга хэмжээнд 300 гаруй хүүхэд хамрагдлаа.

Сумын Шувуухай хүүхдийн цэцэрлэг өвөлжилтийн бэлтгэл ажил хангах хүрээнд өрөө тасгалгаануудын цонх шиллэж, гадна дотно хаалганд дулаалга хийж өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангалаа.

Жюли ББН-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, хортон шавьж, мэрэгч хорхойны устгал халдваргүйжилт хийж, 147 хүүхдийн ахуйн хэрэглээний хэрэглэгдэхүүнийг ариутгаж халдваргүйжүүллээ.

Эрдэнэбүрэн сум: Тайлант сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. 2018 оны 09 дүгээр сарын 29-30-ний өдрүүдэд 5-н багийн Иргэдийн нийтийн хурлыг амжилттай зохион байгуулж, багийн Засаг даргын хийсэн ажлын тайлан хэлэлцэж, Тамгын газрын ажлын хэсэг иргэдэд мэдээлэл хийж иргэдтэй санал солилцлоо.

2. “Цайны зам өв соёлын наадам”-д Өөлдийн ард түмний түүх, соёл, уламжлал зан заншлыг илэрхийлсэн соёлын биет болон биет бус өвийн үзмэрийг дэлгэн иргэдэд түгээж мэдээлэл өгч ажиллав.

3. Аймгийн БОЭТ-ийн Халдвар судлалын их эмч сумын ЕБС-ийн дотуур байр цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж хүүхдийн хөнжил, цагаан хэрэглэл, аяга таваг, бие засах газар болон байгууллагын бүх газар ариутгал хийж эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд ажиллах нөхцөл бүрдүүллээ.

4. Цэцэрлэгийн насны 60 хүүхдэд сумын ЭМТ-өөс амны хөндийн эрүүл ахуй, чих хамар хоолой, шүдний урьдчилан сэргийлэх үзлэг хийж, үзлэгээр шүдний өвчлөлтэй 27, гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй 17 хүүхэд илэрч ЭМТ-ийн хяналтанд авч, эрүүлжүүлэх зохио эмчилгээ хийх арга хэмжээг авч байна.

5. Сумын ОНХС-ийн 2 сая төгрөгөөр Хүүхдийн цэцэрлэгийн зөөлөн эдлэл шинэчилж хүүхдийн хөнжил 40ш, нүүр гарын алчуур 50ш, 70м хивсэн дроз худалдан авч тохижууллаа.

6. Улаанбаатар хот дахь сумын нутгийн зөвлөлийн тэргүүн Б.Мөнхбатын санаачилгаар ХСҮТ-с 4 хүний бүрэлдэхүүнтэй эмч нарын баг 10 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд ажиллаж иргэд хөдөлмөрчдөд эрүү нүүр ам судлал, элэг цөс, хавдрын чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэгийг давхардсан тоогоор 286 хүнд хийлээ.

7. Сумын “Ахмадын баярын өдөр”-ийн арга хэмжээг батлагдсан хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулж, 5-н багийн 183 ахмад тус үйл ажиллагаанд оролцлоо. Багуудаас шалгарсан 5 ахмадын хөдөлмөрийн алдрыг тэмдэглэж салбар бүрт амжилттай ажиллаж хөдөлмөрлөж байгаа тэргүүний ахмадуудад мөн хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулав.

8. “Гүмүда өргөө” ХХК улсын төсвийн 50 сая төгрөгөөр сумын Соёлын төвийн барилгын дээврийг шинэчлэх, гадна фасадны засал чимэглэлийн ажлыг гүйцэтгэж ажлын комисс хүлээн авч ашиглалтад орууллаа.

9. Монголын багш нарын эрхийг хамгаалах өдрийг 2018 оны 10 дугаар сарын 05-ний өдөр зохион байгуулж мэргэжлээрээ амжилттай ажиллаж байгаа багш, сурган хүмүүжүүлэгч болон үе үеийн ахмад багш нарт хүндэтгэл үзүүллээ.

10. Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Сум сурталчлах өдөр”-ийг Ховд аймагт 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Тус өдрөөр Галдан бошигт хааны хөшөөнд цэцэг өргөж, Галдан бошигт хаан, Ану хатан тэргүүтэй 30 баатрын жагсаал, 100 хүүхдийн Өөлд бие биелгээ, хөдөлмөрийн алдартнууд, үндэсний Өөлд хувцастай иргэдийн жагсаал, “Нутаг шүтээн” урлагийн тоглолт, Өөлдийн их таван шүтээнд мөргөх, иргэдэд хүндэтгэл үзүүлэх ёслол хүндэтгэлийн арга хэмээг амжилттай зохион байгууллаа.

11. Сумын нийт 360 өрхийн 214500 мал сүрэгт урьдчилан сэргийлэх туулга, угаалга хийхээс мал сүргийн 90 гаруй хувийг хамруулж, бог малд мялзангийн вакцин хийхээс 10 дугаар сарын 28-ний байдлаар 301 өрхийн 196391 мал буюу нийт малын 91.5 хувьд нь хийгдээд байна.

12. Чайна-хуаши ХХК-ний 50 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шураг багийн Усан салдаг, Хонгио багийн Майхны үзүүрт бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор гүн өрмийн 2 худаг гаргалаа.

13. Босоо тэнхлэгийн авто замын Чайна-хуаши ХХК компаний техникийг ашиглан Шураг багийн Ихэрийн хөтлийн замын машин явахад хүндрэлтэй хэсгийг засварлав.

14. Хонгио багийн малчдын хүсэлтээр Улаан үзүүрийн усны гарамд 12 сая төгрөгийн өртөг бүхий 6ш гүүр хоолой тавьснаар малчид тээвэр хийх, бэлчээр ашиглах нөхцөл бүрдлээ.

15. Энэтхэгийн хүмүүнлэгийн байгууллагаас сумын олон хүүхэдтэй 1 өрхөд 100000 төгрөгийн, нийт 30 өрхөд 3 000 000 төгрөгийн хүнсний тусламж олгосныг сумын удирдлагууд гардуулан өгөв.

Мөнххайрхан сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 хуралдаан 10 дугаар сарын 05-ны өдөр хуралдаж, 5 дугаар хуралдаанаас гарсан санал шүүмжлэлийн мөрөөр хийсэн ажил, түүний хэрэгжилтийн тухай илтгэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж буй ажлын гүйцэтгэл, сум хөгжүүлэх сангийн зээлийн хэрэгжилт, эргэн төлөлтийн явцын тухай мэдээлэл, сумын хэмжээнд өвөлжөө, хаваржаа эзэмшүүлэх, эрх шилжүүлэх журам батлах, зарим газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай, байгаль хамгаалах нөхөрлөл байгуулах хүсэлтийг дэмжих эсэх тухай, Монгол улсын Засгийн газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн тухай илтгэл 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Сумын ЗДТГ байгууллагын шуурхай яриа 3 удаа, аппаратын хурал 1 удаа хуралдаж, байгууллагын дотоод журмыг шинэчлэн батлах, дундын санг байгуулах, үйлдвэрчний эвлэлд нэгдэх талаар асуудлуудыг хэлэлцэв. Шуурхай зөвлөгөөнөөр цаг үеийн ажлын талаар, бог малд мялзангийн вакцин хийх ажлын зохион байгуулалт, сумын төвийн орчмын золбин болон эзэнгүй нохой устгах, нохойны тооллого судалгаа гаргаж, татвар төвлөрүүлэх, нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах, орчны хог цэвэрлүүлэх тухай асуудлуудыг хэлэлцэв.

Мөн сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хурал 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж, архи, тамхи худалдаалах цэгүүдэд хяналт

шалгалт хийх график гаргаж мөрдөх, өсвөр насны сурагчдад хууль дүрэм, зөрчил, хүмүүжил төлөвшлийн талаар сургалт мэдээлэл өгч, ярилцлага зохион байгуулах, нөлөөллийн арга хэмжээ авах, өсвөрийн цагдаа бүлгийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх, малын хулгайтай тэмцэх бүлгийг баг бүрт байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллав.

Хурлаас гарсан шийдвэрийн дагуу 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 14.00 цагаас 6-12 дугаар ангийн сурагчдад сумын Засаг даргын Тамгын газрын Эрх зүйн ажилтан “Архи, тамхи, мөрийтэй тоглоом, цахим дондолтоос сэргийлэх нь” сургалт хийж, Эрүүгийн хуулийн зарим заалт, зөрчлийн тухай хуулийн зарим заалтын талаар танилцуулж, сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтан “Хүүхдийн хүмүүжил төлөвшил, орон нутгийн хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, албан тушаалтан, тэдний үйл ажиллагааны танилцуулга” сэдвээр мэдээлэл өгч, сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгч сурагчдын дундах зөрчил цаашид анхаарах асуудал, зам тээврийн осол, ахуйн осол гэмтлээс сэргийлэх талаар мэдээлэл өгч, зөвлөлийн дарга сурагчдад зөвлөлийн ажил, бүрэлдэхүүн, цаашдын зорилтын талаар танилцуулж мэдээлэл хийв.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын ахмадын хорооны хүсэлтийн дагуу 10,0 сая төгрөгийн өртөгтэй 8:8 м харьцаатай модон байшинг сумын Б.Чинбат, Мөнгөнхөлөг нарын бүлэг барьж ашиглалтанд хүлээлгэн өгч, сумын ахмадын хорооны барилгын нээлтийн арга хэмжээ, ахмадын баярыг 10 дугаар сарын 04-ний өдөр тэмдэглэн, 98 ахмад настан оролцож, төрөл бүрийн хөгжөөнт тэмцээн явуулж, баярыг зохион байгуулалттай тэмдэглэн өнгөрүүлээ.

Сумын Засаг дарга Улаанбаатар хотод 10 дугаар сарын 17-22-ны өдрүүдэд ажиллаж, Хоршоологчдын холбооны 8 дугаар их хурал, хэрэглэгчдийн эрхийг хамгаалах улсын зөвлөгөөнд оролцож, “Миний ховд” язгуур урлагийн анхдугаар наадамд сумын төлөөллийг оролцуулж, ирэх оны улсын төсөвт сумын соёл спортын цогцолбор бариулах хүсэлт уламжлан 2 тэрбум төгрөгийн төсөвтэй барилгын зураг төсөв хийлгэх, Тавтаас сумын төв хоорондох зам засварын ажилд 600 сая төгрөг тусгуулахаар шийдвэрлүүлж, зураг төсөв хийлгэхээр тохиролцов. Мөн шинэ ахмадын өргөөг шинэ ширээ сандалтай болгох асуудлыг О.Батнасан гишүүнд уламжилж, шийдвэрлүүлэв. Мөн сумын Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварын ажлын зураг төсвийг хийлгэж, “Өвсний үндэс” төсөлд санал хүргүүлж ажиллав.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч Х.Болдбаатар, сумын Засаг дарга нар хамтран Хаг, Борт багийн 40 гаруй айл өрхийн амьдралтай танилцаж өвөлжилтийн бэлтгэл, аймаг, сумын цаг үеийн мэдээлэл, бодлого шийдвэрийг танилцуулж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч, уулзаж ярилцав.

“Хуулиа мэдье, мөрдье” аяны хүрээнд туг аялуулж, ерөнхий боловсролын сургуульд шилжүүлж, үйл ажиллагаандаа мөрдөгдөх, хууль дүрэм, журам, заавар стандартын хэрэгжилтийг хангах, сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажлаа эхлүүлээд байна.

Хүнсний эрхийн бичгээр хоол хүнс авдаг халамжийн үйлчилгээнд хамрагдсан 13 өрхийн төлөөлөл иргэдэд, Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн халамжийн хууль дүрэм, төсөл хөтөлбөрийн талаар танилцуулж, ярилцлага зохион байгуулав. Сумын эрүүл мэндийн төвөөс “Сүрьеэ өвчнөөс сэргийлэх”, “Аюулгүй хүнсний 5 зарчим”, “Гэр ахуйн ариун цэвэр, хувийн ариун цэвэр сахих дэглэм, ач холбогдол” сэдвээр сургалт, Засаг даргын Тамгын газрын Эрх зүйн ажилтан “Гэр бүлийн харилцаа, хөгжил, хамгаалал” сэдвээр сургалт хийж, хүний эрхийн зөрчлийн талаар судалгааны асуулга авч ажиллав.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүсэлт уламжлан тус хэлтсийн ахлах мэргэжилтэн, тэтгэврийн байцаагч нар 2018 оны 10 дугаар сарын 04-ны өдөр Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд “Нийгмийн даатгалын хуулийн нэмэлт өөрчлөлтүүд нийгмийн даатгалын сангийн зарцуулалтын тайлан, цаашдын зорилтын талаар 27 хүнийг хамруулан сургалт хийж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох иргэдийн бичиг баримттай танилцан хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулав.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн төслийг Мөнххайрхан уулын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн иргэдэд танилцуулж, санал авах хэлэлцүүлэгт 14 хүн оролцож, өөрчлөн сайжруулах 26 асуудлыг дэвшүүлэн санал дүгнэлт гаргаж ажиллав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохион байгуулалттай туршилтын ажлын байрны төсөлд ажилгүй, ажил идэвхтэй хайж буй 8 иргэнийг бүлэг болгон Хөх сайгийн зам засах, Битүү нуурийн мод цэвэрлэх, Сэнхэрийн гол цэвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж, өвчний учир байнгын асаргаа шаардлагатай 3 иргэнийг асаргаанд оруулж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн судалгаа гаргаж аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 20 өрхөөс сэтгэл ханамжийн судалгаа авч, өрхүүдэд мэдээлэл өгөхөөс гадна улиралд нэг удаа бүтээлч ажлаар сумын урд Улаан уулын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэхээр болов.

Нийгмийн даатгалын орлого төвлөрүүлэлт 2018 оны 10 дугаар сарын 24-ний байдлаар аж ахуйн нэгж байгууллагуудын шимтгэлд 15396,1 мян төгрөг, сайн дурын даатгалд 26 иргэнийг хамруулж 854,4 мян төгрөг, эрүүл мэндийн даатгалд 49 иргэнийг хамруулж 1928,6 мян төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлээд байна.

Тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголт тайлант сард 275 иргэнд 81449,5 мян төгрөгийн тэтгэвэр олгосон бөгөөд шинээр 5 иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоож, “Цахим нийгмийн даатгалын үйлчилгээг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд 6 иргэн ухаалаг гар утсанд нийгмийн даатгалын апплейкшн суулгаж, нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ, мэдээллийг гар утаснаасаа авах боломжийг бүрдүүлж ажиллав.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Өвөлжөө хаваржаа эзэмшүүлэх эрх шилжүүлэх журам”, “Ус цаг уур орчны шинжилгээний газрыг улсын тусгай хэрэгцээнд

авах тухай”, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол гарсантай холбогдуулан “Газрын төлбөрийн хувь хэмжээ тогтоох тухай” асуудлуудыг бэлтгэн хэлэлцүүлж, сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн тогтоол гаргуулан ус цаг уур орчны шинжилгээний газрын ус судлалын харуулын талбай, ажиглалтын талбайн тусгай хэрэгцээнд авсан газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтэст бүртгүүлэхээр хүргүүлэв.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 10 дугаар сарын 10-12 хооронд Бэлчээрийн ургамлыг фотомониторингийн аргаар үнэлснээ Газрын ланд менежер программ оруулах аргачлалын сургалтанд сууж 2018 оны ургамлын судалгааны мэдээлэл оруулсан.

Хаг багийн Улиастын газарт байгаа 8 өвөлжөө хаваржааны цэгийг GPS-ээр хэмжилт хийж, маргаантай газартай танилцан, ЛМ программд өвөлжөө хаваржааныг бүртгэлийг оруулж, мэдээллийн баазыг сайжруулж байна. Эрүүл мэндийн төв, “Ховд Цэнхэрийн долгио” ХХК-уудын газрын хэмжээ талбай өөрчлөн гэрээ гэрчилгээг сольж, хувийн хэргийн бүрдүүлэлтийг баяжуулан цахимжуулав.

Мөнххайрханы БЦГ-ын байгаль хамгаалагч нарын мэдээллийн санг ARCGIS программд оруулж, газарзүйн мэдээллийн сан үүсгэв.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу “Аялал жуулчлалыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр боловсруулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн 6 дугаар хуралдаанаар тус сумын Алаг багийн “Нэг сэтгэлтэн” байгаль хамгаалах нөхөрлөлийн хүсэлтийг хэлэлцүүлэн хамгаалах газар нутгийн хэмжээ, нөхөрлөлд гэрээгээр олгох асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зарласан “Ногоон паспорт-Монгол орон даяар” аяныг эхлүүлээд байгаа бөгөөд ногоон паспорт түүний ач холбогдлыг таниулах, хөтлөх зааварчилгааны дагуу сумын Ерөнхий боловсролын сургуулийн 7-12 дугаар ангийн сурагчдад мэдээлэл өгч, ногоон паспорт олгох ажлыг зохион байгуулав.

Цэцэрлэгийн насны хүүхдүүдийн нийт эцэг эхийн хурал 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хийж, 6 төрлийн асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. 51 эцэг эх оролцсон. Бэлтгэл, ахлах, дунд, бага бүлгийн эцэг эхийн хурлыг тус бүр нэг удаа хуралдуулж, бэлтгэл бүлгийн 18, ахлах бүлгийн 15, дунд бүлгийн 17, бага бүлгийн 15 нийт 65 эцэг эх оролцуулан хуралдуулж, багшийн үйл ажиллагааг дэмжих, хүүхдэд өгөх усыг эцэг эх нь өглөө бүр усны саванд хийж бэлтгэж өгөх, буддаг ном, өнгө ялгах тоглоом, могой шоо зэрэг тоглоомыг хүүхэд бүрт эцэг эх нь авч өгөхөөр шийдвэрлэж, хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар шинэ хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах санал авах ажлыг зохион байгуулав. Мөн бага бүлэг эцэг эхийн тусламжтайгаар ус цэвэршүүлэгчтэй болсон.

Багш ажилтны хурлыг 4 удаа хийсэн. Цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, ирсэн бичиг, дээд байгууллагын тогтоол, шийдвэрүүдийг танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дунд бүлгийн хувцасны өрөө, ариун цэврийн өрөөг тусгаарлаж хувцасны өрөөг унтлагын өрөө болгож тохижуулсан ба ариун цэврийн өрөөний хаалгыг өөрчилсөн. Багш ажилтан бүр 3 ш улавч оёж тавьснаар эцэг эхчүүд улавчаа тогтмол өмсөж хэвшсэн.

Сумын Эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээнд эмийн бус эмчилгээгээр 30 хүнд үйлчилсэн. Урьдчилан сэргийлэх зорилгоор 0-2 насны 25 хүүхдэд товлолын дархлаажуулалтанд 100 хувь хамруулсан.

Сумын харьяат аймгийн төвд оршиг суугаа зорилтот бүлгийн иргэдийг эрт илрүүлэгийн үзлэг, шинжилгээнд хамруулж, 15-39 насны нийт 61 хүнийг элэгний В,С вирус илрүүлэх, Дох, Тэмбүүгийн шинжилгээнд хамруулсан. Артерийн гипертензия, чихрийн шижингийн эрт илрүүлэгт 21 хүн хамрагдсан, 8 хүнд хөнгөлөлттэй эмийн жороор үйлчилсэн.

Нэгдсэн үндэсний байгууллагын ерөнхий Ассамблейгаас 2008 оны “Олон улсын ариун цэврийн жил” болгосонтой холбогдуулан жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийг “Дэлхийн гар угаах өдөр” хэмээн тунхаглаж дэлхий даяар эрүүл ахуйн дэглэм сайжруулахыг уриалсны дагуу энэхүү өдрийг сургууль, цэцэрлэгийн байгууллагатай хамтран дотуур байрны багш нарт “Гараа угаах дараалал, гарын ариун цэвэр”-ийн талаар сургалт зохион байгуулж, цэцэрлэгийн багш, хүүхдүүдэд гар угаах талаар боршур, сурталчилгаа зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд бохир гараас дамжих халдварт өвчнөөс сэргийлэх ач холбогдолтой.

Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдад “Эх хүүхдийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөж буй эрхзүйн баримт”, “Уян зүү тавих арга техник” сэдэвт дотоодын сургалтыг зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд Эмч, ажилчдын ур чадварыг сайжруулах, яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлэхэд үр дүнтэй юм.

Сумын Соёлын төвийн ажилчид аймагт зохион байгуулагдсан “Цайны зам өв соёлын наадам”-д 18 хүний бүрэлдхүүнтэй амжилттай оролцов. Ахмадын өргөөний нээлтэнд зориулсан ахмадын баярын хүлээн авалт болж 50 гаруй ахмадуудад оролцсон баярын үйл ажиллагааг зохион байгуулав. Хүлээн авалтын үеэр “Аха” тэмцээн, урианхай дууны уралдаан, танин мэдэхүйн сугалаат тэмцээнүүдийг тус тус зохион байгууллаа. Мөн сумын бүрэн дунд сургуулийн 12 дугаар ангийн “Насаараа бид нэг ангийнхан” тоглолтыг бэлтгэн тоглуулав. Тоглолтыг 200 гаруй хүүхэд багачууд 100 орчим насанд хүрэгчид үзэж сонирхлоо. Монголын багш нарын баярт зориулан нийтийн цэнгээнт бүжиг зохион байгуулж 100 орчим багш сурагчид оролцсон

Сумын Ерөнхий боловсролын сургууль жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Намрын спартакиад” арга хэмжээг 10 дугаар сарын 6-10-ны өдрүүдэд тус сургуулийн 2-12 дугаар ангийн 400 гаруй сурагчдын дунд зохион байгуулж, энэ жилийн шилдгүүдээ шалгарууллаа. Тус тэмцээнд багийн нэгдсэн дүнгээр 12, 9, 5 дугаар ангиуд амжилттай оролцож шилдгүүдээ шалгарууллаа.

Өсвөрийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, бөхийн спортыг сурталчлах, хүүхдийн авьяасыг нээж илрүүлэх зорилгоор жил бүр сургуулийн аварга шалгаруулах бөхийн тэмцээнийг явуулж хэвшсэн. Энэхүү тэмцээн 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээн жүдо бөхийн төрлөөр эрэгтэй, эмэгтэй тус бүр 7 жин, үндэсний бөх 2 насны ангилалаар зохион байгуулагдаж шилдгүүдээ тодрууллаа.

Багш нарын баярыг 10 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн нийт багш нарын дунд волейболын тэмцээн, сурагчдын дунд зохион бичлэг, гар зураг, талархлын захидлын уралдаан, баярын хурал, цэнгүүн, тэргүүлэх зэрэгтэй багш нарын үзэсгэлэн зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагаанд тус сургуулийн 54 багш, ажилчид, 470 гаруй сурагчид хамрагдаж, З.Нарантуяа багштай 12 дугаар ангийн сурагчдын “Насаараа бид нэг ангийхан” тоглолт 10 дугаар сарын 05-ны өдөр сумын соёлын төвд зохион байгуулагдсан.

Дотуур байрны урлагийн үзлэг 10 дугаар сарын 24-ны өдөр дотуур байрны зааланд зохион байгууллаа. Тус тэмцээнд Д.Жанаргүль багштай SMILE баг амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн. Энэхүү тэмцээнд 4 багийн 50 гаруй сурагч хамрагдлаа.

Жаргалант сум: Сумын Засаг даргын тамгын газрын даргын 2018 оны А/01 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, үр дүнгийн гэрээнд заагдсан мэдлэг ур чадварыг сайжруулах зорилгоор 7 хоног бүрийн Баасан гаргийн 08-10 цагийг сонсгол мэдээллийн цаг болгон төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг сайжруулан ажиллаж байна.

УИХ-ын гишүүн С.Бямбацогтын дэмжлэгээр зохион байгуулагдах, багийн үйл ажиллагааны төсөл хөтөлбөр 2019 онд багуудын дунд зохион байгуулагдах уралдааны удирдамж төлөвлөгөөг боловсруулан хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Мөн 2019 оны улсын төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулан 2019-2020 онд улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудыг сумын хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан боловсрууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөр тусгах саналын хэлэлцүүлэгт хамрагдаж санал оруулав.

Багийн ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй, асаргаанд байдаг иргэдийн эмчилгээний зардал болон рашаан сувилалд амраад ирсэн зардал, байнгын асаргаанд орж буй иргэн, жирэмсэн эх тэдгээрийн материалуудыг бүрдүүлэн авч Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлэв.

“Олон улсын ахмадын баяр өдөр”-ийг тохиолдуулан хийн дасгал, язгуур урлаг, спортын тэмцээнийг Жаргалант сумын 12 багийн ахмад настнуудын дунд амжилттай зохион байгуулж шилдэгүүдээ шагнаж урамшууллаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэн бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд 42 байгууллагын 908 иргэн оролцож 1585 ширхэг бургас, 407 ширхэг хайлаас тарьж нийт 1992 ширхэг мод бут таригдаж 2414000 төгрөг

зарцуулж, мод тарих ажилд оролцоогүй албан байгууллагуудаас нэг хүний 4000 төгрөгийг хураан авч Жаргалант сумын дансанд 173400 төгрөг төвлөрүүлээ.

Сумын Засаг даргын 2018 оны А/233 дугаар захирамжийг хэрэгжүүлэн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан ажиллалаа. Албан байгуулага, аж ахуйн нэгжүүдээр өөрийн эзэмшлийн болон түүний орчмын 50м хүртэлх газрыг бүрэн цэвэрлүүлж нийт 5 машин буюу 15 м³ хог хаягдлыг төвлөрсөн хогын цэгт буулгаж устгав.

Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2018 оны А/01 дугаар тушаал, сумын Засаг даргын А/284 дугаар захирамжийн дагуу бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын арга хэмжээний хүрээнд 53 малчин, мал бүхий иргэдийн 35098 толгой малыг мялзангийн вакцинжуулалтанд хамруулаад байна.

Жаргалант сумын хэмжээнд 2018 оны 10 дугаар сарын байдлаар 134 иргэн, 7 аж ахуйн нэгжээс ургац хураалтын мэдээ тайланг гаргаж холбогдох газарт мэдээллээ.

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд төмс 611тн, хүнсний ногоо 1444,1тн, тэжээлийн ургамал 70,2тн, жимс, жимсгэнэ 14,4тн тариа 22тн, хураасан хадлан 759тн, гар тэжээл 145тн, хужир 320тн тус тус хураан авч өвөлжилтийн бэлтгэлийг хангаад байна.

Жаргалант сумын 12 баг Монгол Улсын Засгийн газар болон аймаг, сумын Засаг даргын “2016-2020” оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэн ажиллаж байна.

Хүн ам өрхийн мэдээллийн санд сар бүр шилжилт хөдөлгөөн, нас баралт, шинээр төрсөн иргэний мэдээллийг гарган шинэчлэлт хийж баяжуулан ажиллаж байна. ХАӨМС программ шинэчлэгдсэнтэй холбоотой үүссэн өрхийн мэдээллийн алдааг засаж ажиллав.

Мянгад сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2018 оны тайлант сард Тэргүүлэгчдийн хуралдааныг 2 удаа хийж нийт 4 асуудал хэлэлцүүлэн шийдвэрлэсэн ба “Төлөөлөгч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төлөөлөгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Чингэлтэй дүүрэг, Дорнод аймгийн Халх гол сумын ИТХ-ын үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцов.

Аймгийн нутгийн зөвлөл, Мянгад сумын нутгийн зөвлөлөөс зохион байгуулсан “Миний ховд” язгуур урлагийн анхдугаар уралдаанд 35 хүний бүрэлдэхүүнтэй оролцон Шилдэг зохион байгуулалттай сумаар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Иргэний гэр бүлийн бүртгэл, улсын бүртгэлийн чиглэлээр, төрөлт 10, гэрлэлт 1, эцэг тогтоолт 3, нас баралт 3, шилжин явсан 11, шилжин ирсэн 7, иргэний цахим үнэмлэх шинээр 12, /25/45 насны сунгалт 12, гээгдүүлсэн 2, нөхөн бүртгэл 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр хашаа байшингийн гэрчилгээ 1, Газрын гэрчилгээ 2, нийт 48 иргэний өргөдөл хүсэлт хүлээн авч бүртгэлд хамруулан гэрчилгээжүүллээ.

Цэцэрлэгийн 4 бүлэгт 115 хүүхэд хүмүүжиж байгаа ба цэцэрлэгийн багш удирдах ажилтнууд багш нарын мэргэжил дээшлүүлэх институт, Боловсрол соёл

урлагийн газраас зохион байгуулсан “Байгууллага, байгууллагын соёл” сэдэвт сургалт, “Олон нийтийн оролцоо” зөвлөгөөнд хамрагдлаа.

Сумын Эрүүл мэндийн төв 512 иргэнд амбулаторийн үзлэг хийж, 21 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 18 удаа алсын дуудлагад явж, 0-3 сартай таван жирэмсэн эхийг хяналтанд авлаа. Товлолын дархлаажуулалтыг 0 сартай БЦЖ, В гепатит, САА вакцин 1 хүүхдэд, 2 сараас 4 сартай нийт 21 хүүхдэд Тавт вакцин, САА, 9 сартай 7 хүүхдэд Улаанбурхан, Улаануудын эсрэг вакцин, 1,2 настай 2 хүүхдэд А гепатитын эсрэг вакцин, 2 настай 8 хүүхдэд Улаанбурхан, Улаануудын эсрэг вакцины 2 дахь тунг, нийт 39 хүүхдийг товлотт вакцинд бүрэн хамруулсан.

Элэг бүтэн-Монгол хөтөлбөрийн хүрээнд 15-39 насны 107 иргэн, ЕБС-ийн 370 сурагч, Цэцэрлэгийн 4 бүлгийн 129 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. “Итгэл хавдаргүй сан”-тай хамтран төрөх насны 75 иргэнийг ХСҮТ-ийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, умайн хүзүүний хавдрын эсийн шинжилгээнд хамрууллаа.

Сумын Ерөнхий боловсролын сургууль “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, цахим орчны хор нөлөө, цахим орчны зохистой хэрэглээ” архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, архи тамхины хор нөлөө, архи тамхины хяналтын тухай хууль” – иар сургалт хэлэлцүүлгийг 6-12 дугаар анги, дотуур байрны сурагчид, багш ажилчдад мэдээлэл хийж 510 гаруй иргэн хамрагдлаа.

Сумын Номын сангаар 63 иргэн үйлчилүүлж давхардсан тоогоор 352ш номыг танхим, гэрээр олгосон ба дуу хөгжим, бүжгийн дугуйланд нийт 31 хүүхэд хамрагдан суралцаж байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр 56 иргэнд 8680.0 мянган төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 28 иргэнд 1120.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж 11 иргэнд 770.0 мянган төгрөг, ахмад настан асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж 32 иргэнд 2240.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч буй 14 иргэнд 980,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 13 хүүхдэд 2015,0 мянган төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд 5 эхэд 250000 төгрөг тус тус олголоо. Хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт нийт 22 өрхийг хамруулан хүнсний эрхийн бичиг олгож, 1736.0 мянган төгрөгийг Мянгад-Ану дэлгүүрт шилжүүлж худалдан авалт хийгдлээ.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд шимтгэлийн орлого 19512.3 мянган төгрөг, сайн дурын даатгалд 41 иргэнээс 2255.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 22 иргэнээс 1358.0 мянган төгрөг нийт 23125.3 мянган төгрөг орууллаа.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 119995.0 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврт 318 хүнд 98290.0 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэврт 38 иргэнд 6120,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврт 78 иргэнд 15585,0 мянган төгрөг, ҮОМШӨ-ий сангаас 1 иргэнд 332.6 мянган төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмжит 3 иргэнд 3998,2 мянган төгрөг, оршуулгын тэтгэмжит 2 иргэнд 2000.0 төгрөг нийт 126325.8 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид тус тус олголоо.

Төрийн сангийн фрийбаланс программаар орон нутгийн байгууллагын 27.812.600 төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 121.719.314 төгрөгийн санхүүжилт хуваарилан гүйлгээ хийгдлээ. Тайлант сард орон нутгийн төсвийн орлогод 10568.5 мянган төгрөг оруулж 10 дугаар сарын төлөвлөгөөг 341.2 хувиар биелүүлсэн ба “Зэвсэг-2018” арга хэмжээний хүрээнд сумын Цагдаагийн тасагтай хамтран 54 галт зэвсгийг бүртгэлд хамрууллаа.

Сумын нутаг дэвсгэрт 10 мегаваттын нарны цахилгаан станц барих талбай бэлтгэх зорилгоор Дэлхийн банкны 160.0 сая төгрөгийн хөрөнгөөр Зөөлөн тэмүүлэл констракшн ХХК 20.07 га талбайн 18 мян куб.м хог хаягдал цэвэрлэхээр тендерийн бичиг баримтад тусгагдсан боловч сум орон нутгийн удирдлагаас тавьсан саналын дагуу 45.8 га талбайн 42 мянган куб.м хог хаягдлыг булшилж, байгаль орчинд нөлөөлөлгүй болголоо

Баянхошуу багийн төвд нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж 5 албан байгууллагын 84 ажилтан албан хаагч, ЕБСургуулийн ахлах ангийн 74 сурагч ажиллаж нийт 43.5 га талбайн 8.3 тонн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт хүргэлээ.

Өвөлжилт хаваржилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд сумын хэмжээнд 650 тн байгалийн хадлан, 350 тн гар тэжээл, 850 тн хужир шүү бэлтгэгдсэн. Бизнесийн зориулалтаар 25 иргэн Гахайт багт 15000 боодол Цагаанбулан багт 60000 боодол өвс бэлтгэж аймгийн өвсний фондод нийлүүлээ.

Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн 12 иргэний өвөлжөө хаваржааны зориулалтаар газар эзэмших 18 өргөдөл хүлээн авч Засаг даргын захирамж гаргаж гэрээ байгуулан гэрчилгээжүүлж, газрын төлбөр төлөгч иргэн аж ахуйн нэгж байгууллагуудаас 2200,8 мянган төгрөгийг хураан авч аймгийн төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР